

БОЛОВСРОЛЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ДЭЛХИЙН ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ

2021/2

Боловсролын салбар дахь төрийн бус оролцогч талууд:

ХЭН СОНГОЖ, ХЭН АЛДАХ ВЭ?

unesco

Тогтвортой Хөгжлийн Зорилго

Боловсролын хяналт-шинжилгээний дэлхийн тайлан

БОЛОВСРОЛЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ
ДЭЛХИЙН ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ

2021/2

Боловсролын салбар дахь төрийн бус оролцогч талууд:

ХЭН СОНГОЖ, ХЭН АЛДАХ ВЭ?

Инчоны Боловсрол 2030 тунхаглал, үйл ажиллагааны хүрээнд Боловсролын хяналт-шинжилгээний дэлхийн тайлангийн үүргийг тодорхойлохдоо "ТХЗ-уудын ерөнхий хэрэгжилтийг хянан үзэх, тоймлон дүгнэх ажлын хүрээнд үүрэг хүлээсэн холбогдох талуудыг үндэсний болон олон улсын стратегийн хэрэгжилтийг тайлагнах" хариуцлагын хамт "ТХЗ 4 болон боловсролын асуудлыг тусгасан бусад ТХЗ-ын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, тайлагнах механизм болно" гэжээ. Тайланг ЮНЕСКО-ийн бие даасан баг боловсруулан гаргадаг.

Энэхүү хэвлэлд ашигласан тодорхойлолт, нэр томьёо болон бусад материалын танилцуулга нь аливаа улс орон, газар нутаг, хот, бүс нутгийн хууль эрх зүйн байдал, түүний эрх бүхий байгууллага, удирдлага эсхүл түүний хил хязгаарыг тогтоох, хязгаарлах талаар ЮНЕСКО-ийн зүгээс ямар нэг байр суурь илэрхийлж буй хэрэг биш болно.

Уг тайланд дурдсан баримтуудын сонголт, танилцуулга, түүнчлэн илэрхийлэгдэж байгаа үзэл бодол, байр суурийн хариуцлагыг гагцхүү Боловсролын хяналт-шинжилгээний дэлхийн тайланг боловсруулсан баг хүлээх бөгөөд үүнд ЮНЕСКО-ийн байр суурийг илэрхийлээгүй бөгөөд тийм үүрэг хүлээгээгүй болно. Энэхүү тайланд илэрхийлсэн үзэл бодол, байр суурийн талаарх ерөнхий хариуцлагыг тайлан боловсруулсан багийн захирал хүлээнэ.

Боловсролын хяналт-шинжилгээний дэлхийн тайланг боловсруулсан баг

Захирал: Манос Антонинис

Даниэль Эприл, Билал Баракат, Марсела Мариа Барриос Ривера, Маделайн Бэрри, Кэтэрин Блэк, Николь Белла, Силиа Южиния Калво Гутиерез, Даниэль Каро Васкез, Анна Кристина Д'Аддио, Димитра Дафалия, Дмитри Давидов, Франческа Эдриззи, Констанза Жинестра, Чандни Жайн, Приядаршани Жоши, Мариа-Рафаела Калди, Жозефин Киенже, Крэйг Лэйрд, Катие Лазаро, Кэйт Линкинс, Камила Лима Дэ Мораэс, Кассиани Литрангомитис, Анисса Мехтар, Клаудин Мукизва, Юки Мураками, Мануэла Помбо Поланко, Жудит Рандрианатоавина, Кэйт Рэдмэн, Мариа Рожнов, Лаура Стипанович, Улрич Йансе ван Вуурен, Жулиана Запата, Лема Зекриа, Жиахэн Жу.

Боловсролын хяналт-шинжилгээний дэлхийн тайлан нь жил тутмын хараат бус хэвлэл юм. Энэхүү тайланг боловсруулах ажлыг засгийн газруудын, олон талт хөгжлийн агентлагуудын болон хувийн сангуудын нэгдэл санхүүжүүлж, ЮНЕСКО-ийн зүгээс зохих дэмжлэг үзүүлж, зохицуулалт хийсэн болно.

Энэхүү лиценз нь зөвхөн текстэд хамаарна. Зургийг ашиглахаар бол урьдчилан зөвшөөрөл авах шаардлагатай.

ЮНЕСКО нь Нээлттэй хандалтын нийтлэгч бөгөөд бүх хэвлэлийг тус байгууллагын баримтын сангаас үнэ төлбөргүй авах боломжтой. ЮНЕСКО-ийн аливаа хэвлэлийг арилжааны зориулалтаар ашиглах нь цаас эсвэл CD дээр хэвлэх,хуулбарлах,түгээх зэрэгтэй холбоотой бодит зардлыг нөхөх зорилготой юм. Аливаа ашгийн зорилго байхгүй болно.

Энэхүү хэвлэлийг дараах байдлаар эх сурвалж болгон ашиглаж болно: ЮНЕСКО. 2021. Global Education Monitoring Report Summary 2021/2022: Non-state actors in education: Who chooses? Who loses? Парис хот,ЮНЕСКО.

©ЮНЕСКО,2021 он
Хоёр дахь хэвлэл
Нэгдсэн Үндэстний Боловсрол,шинжлэх ухаан,соёлын байгууллага (7,Фонтенуа талбай,75352 Парис хот 07 SP,Франц Улс)-аас 2021 онд эрхлэн гаргав.

Эх бичвэр: ЮНЕСКО
График дизайн: Оптима график дизайн ХХК
Эх бэлтгэл: Мөнхийн үсэг ХХК

Хавтасны зураг: Жаап Жорис Венс/ Супер Формоса зургийн студи
Титр: Сургуульд хүрэх өөр өөр замууд,Нидерланд Улс.

Зурсан зургийг Хаусатоник SRL Юниперсонель
Комикс зургийг Хулио Каррион Куэва (Кэрри)ба Мигель Моралэс Мадригал

Инфографик: Хаусатоник SRL Юниперсонель

ED-2021/WS/38

Энэхүү хэвлэлийг Attribution-ShareAlike 3.0 IGO (CC-BY-SA 3.0 IGO) лицензийн дагуу Нээлттэй хандалтад байршуулсан болно (http://creativecommons.org/licenses/by-sa/3.0/igo/). Хэрэглэгчид энэхүү хэвлэлийн агуулгыг ашиглахдаа ЮНЕСКО-ийн Нээлттэй хандалтын сан (http://www.unesco.org/open-access/terms-use-ccbysa-en)-гийн ашиглалтын нөхцөлийг хүлээн зөвшөөрөх шаардлагатай.

Одоо эзэмшиж буй лиценз нь тус хэвлэлийн эхийн агуулгад онцгой эрхтэйгээр хамаарна. ЮНЕСКО-д хамаарах эсэх нь тодорхой бус аливаа материалыг ашиглах тохиолдолд дараах хаягаар зөвшөөрлийг урьдчилан авах шаардлагатай: publication.copyright@unesco.org or UNESCO Publishing,7,place de Fontenoy, 75352 Paris 07 SP France.

Боловсролын хяналт-шинжилгээний дэлхийн тайлангийн цувралууд

2021/2 Боловсролын салбар дахь төрийн бус оролцогч талууд: Хэн сонгож,хэн алдах вэ?
2020 Тэгш хамралт ба боловсрол: Бүх нийт гэсэн бол бүх нийт л байх ёстой
2019 Шилжилт хөдөлгөөн, дүрвэлт ба боловсрол: Хана хэрэм биш гүүр барих нь
2017/8 Боловсролд хариуцлагатай хандах нь: Бидний үүрэг амлалтын биелэлт
2016 Хүмүүс, гараг дэлхийн төлөөх боловсрол: Бүх нийтийн төлөө тогтвортой ирээдүйг бүтээх нь

БНБ-ын хяналт-шинжилгээний дэлхийн тайлангийн цувралууд

2015 Бүх нийтийн боловсрол 2000-2015: Ололт амжилт ба сорилтууд
2013/4 Сургахуй ба суралцахуй: Бүх нийтийн төлөө чанарыг ахиулах нь
2012 Залуучууд ба ур чадвар: Хөдөлмөрт нийцсэн боловсрол
2011 Далд хямрал: Зэвсэгт мөргөлдөөн ба боловсрол
2010 Эмзэг бүлгийнхэнд хүрэхүй
2009 Тэгш бус байдлыг даван туулах нь: Засаглал яагаад чухал вэ
2008 Бүх нийтийн боловсрол 2015 онд: Бид хийж амжих уу?
2007 Бат бөх суурь: Бага насны хүүхдийн асаргаа ба боловсрол
2006 Аж төрөхийн тулд бичиг үсэгт тайлагдахуй
2005 Бүх нийтийн боловсрол: Чанарыг чанд сахихуй
2003/4 Жендэр ба бүх нийтийн боловсрол: Тэгш байдалд хүрэх өөрчлөлт
2002 Бүх нийтийн боловсрол: Дэлхий зөв чиглэлд явж байна уу?

Энэхүү тайлан болон холбогдох материалыг Bit.ly/2021gemreport холбоосоор татах боломжтой.

Боловсролын салбар дахь төрийн бус оролцогч талууд 1

Үндсэн санаа 1
Нийтийн боловсролд үзүүлэх дэмжлэг өндөр байна 3
Олон төрлийн мэтгэлцээн төрийн бус оролцогч талуудын үүргийн төлөө эсвэл түүний 3
эсрэг байр суурийн хэлэлцүүлэгт хүргэж байна .....
Боловсрол дахь төрийн болон төрийн бус оролцогч талуудын тухай цуу яриа 5
Хангамж 9
Засаглал ба эрх зүйн зохицуулалт 10
Санхүү 11
Нөлөөлөл 13
Бага насны хүүхдийн асаргаа ба боловсрол 14
Дээд боловсрол 15
Техник, мэргэжлийн болон насанд хүрэгчдийн боловсрол 16
Зөвлөмж 17

Тогтвортой хөгжлийн зорилго дахь боловсролын салбарын хяналт шинжилгээ 21

КОВИД-19 22
Зорилт 4.1. Бага, дунд боловсрол 25
Зорилт 4.2. Сургуулийн өмнөх боловсрол 25
Зорилт 4.3. Техник, мэргэжлийн,дээд болон насанд хүрэгчдийн боловсрол 26
Зорилт 4.4. Хөдөлмөр эрхлэх ур чадвар 27
Зорилт 4.5. Тэгш байдал 27
Зорилт 4.6. Бичиг үсэг тайлагдалт,тоо бодох чадвар 28
Зорилт 4.7. Тогтвортой хөгжил ба дэлхийн иргэншил 29
Зорилт 4.a. Боловсролын байгууламж, сургалтын орчин 29
Зорилт 4.b. Тэтгэлэг 29
Зорилт 4.c. Багш нар 30
Бусад ТХЗ-ын боловсролын асуудал 30
Санхүүгийн хяналт-шинжилгээ 31

Боловсролын салбар дахь төрийн бус оролцогч талууд

ҮНДСЭН САНАА

Боловсролын салбарт төрийн бус оролцогч талууд оролцоогүй хэсэг гэж байхгүй.
Энгийнээр хэлбэл,төрийн бус оролцогч тал байхгүй бол 350 сая гаруй хүүхдийн боловсролыг төр дангаар хариуцах болно. Гэхдээ төрийн бус оролцоо нь тэдний хэрэглэж буй сурах бичиг,цайны газрын хоол,тэдний авч буй нэмэлт дэмжлэг,сурсан ур чадвар болон бусад олон зүйлд нөлөөлдөг.

Ихэнх хүмүүс нийтийн боловсролын тогтолцоог дэмждэг.
Дунд болон өндөр орлоготой 34 орны дөрвөн хүн тутмын гурав нь улс орны тэгш бус байдал ихсэж буйг харгалзан улсаас үзүүлдэг боловсролын үйлчилгээнд хөрөнгө зарцуулахыг илүүд үздэг. Арван хүний ес орчим нь боловсролыг юуны түрүүнд улсаас үзүүлдэг үйлчилгээ байх ёстой гэж үздэг.

Гэвч бага, дунд орлоготой зарим улс, оронд энэ төрлийн дэмжлэг аажмаар замхарч алга болж байна.
Төрийн өмчийн сургуулиудын хангамж,хүрэлцээ,чанар муудах үед ихэнх айл өрх сургуулийг орхин явах замаар дургүйцлээ илэрхийлдэг. Дэлхий даяар хувийн хэвшлийн байгууллагуудын эзлэх хувь 10 орчим жилийн хугацаанд 7 хувиар нэмэгдсэн бөгөөд 2013 онд бага боловсролын дэд салбарт 17 хувь,2014 он гэхэд дунд боловсролын дэд салбарт 26 хүртэл хувиар өссөн байна. Түүнээс хойш энэ үзүүлэлт тогтмол хэвээр байна. Төв болон Өмнөд Азийн орнуудад төрийн бус өмчийн сургуулийн элсэлтийн эзлэх хувь бага боловсролд 36 хувь,дунд боловсролд 48 хувь байна.

Нийтийн боловсролын тогтолцоо үнэ төлбөргүй биш юм.
Дэлхий хэмжээнд боловсролын нийт зардлын 30 хувийг, бага болон дундаас доош орлоготой орнуудад 39 хувийг айл өрх бүрдүүлдэг. Энэ нь чинээлэг гэр бүлүүд хүүхдүүддээ өрсөлдөхүйц давуу тал олгохыг хичээдэгтэй холбоотой. Гэвч засгийн газрууд үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлэх үүрэг хүлээсэн сургуулийн өмнөх, бага, дунд боловсролын дэд салбарт төсвийн ихээхэн хэсгийг зарцуулдаг. Айл, өрхүүдийн 8 орчим хувь нь сургалтын төлбөрөө төлөх зорилгоор зээл авдаг бөгөөд энэ үзүүлэлт бага орлоготой улс,орнуудад 12 хувь болж өсдөг бол Гаити,Кени,Филиппин, Уганда зэрэг улсад 30 ба түүнээс дээш хувьд хүрдэг байна.

Нийтийн боловсролын тогтолцоо ихэвчлэн тэгш байдлыг хангасан байж чаддаггүй.
Сурагчдын сурлагын амжилтын олон улсын үнэлгээний (PISA) хөтөлбөрийн мэдээлэлд үндэслэн боловсруулсан сургуулийн орчин дахь нийгмийн олон янз байдлын индексийн үр дүнгээс харахад 2018 онд Аргентин, Бразил, Чили, Мексик зэрэг улсууд нийгмийн ялгаатай байдал, ялгаварлан гадуурхалтын түвшин хамгийн өндөр байсныг олж тогтоожээ. Харин Чили Улсын боловсролын тогтолцоонд хувийн сургуулийн эзлэх хувь өндөр байдаг тул шүүмжлэлтэй хандах магадлалтай байдаг.

Аль нэг нь нөгөөгөөсөө илүү чанартай боловсрол олгоно гэсэн ойлголт байхгүй. Бага, дунд орлоготой 30 орны тоо баримтаас харахад өрхийн онцлог шинж чанарыг харгалзан үзвээс хувийн сургуульд сурсны илэрхий давуу тал нь талаас гуравны хоёр хүртэл буурдаг. Түүвэр судалгаанд хамрагдсан 49 улсад хувийн сургуульд суралцах тал дээр чинээлэг өрхүүд бага орлоготой ядуу өрхөөс 10 дахин илүү магадлалтай байдаг байна. Суралцах сургууль сонгох боломжтой эцэг эхчүүд тэдний хувьд маш хязгаарлагдмал мэдээлэл болох чанартай сургалт гэхээс илүү шашны итгэл үнэмшил, ая тухтай байдал, сурагчдын хүн ам зүйн шинж чанараас шалтгаалан ийм сонголт хийдэг.

Хэрэгцээ өндөр шаардлагатай байгаа газарт зохицуулалт, хяналт, хэрэгжилтийн чадавх сул байх хандлагатай байдаг. PEER вэбсайтын 211 боловсролын тогтолцоонд хийсэн дүн шинжилгээнээс зохицуулалт нь бүртгэл, зөвшөөрөл, лиценз (98%), багшийн гэрчилгээ (93%), дэд бүтэц (80%), сурагч/багшийн харьцаа (74%) зэрэг зохицуулалтад ихээхэн анхаарал хандуулдаг. Боловсролын чанар, тэгш боломжид чиглэсэн зохицуулалтад хамгийн бага анхаарал хандуулдаг бөгөөд 67% нь төлбөр тогтоох асуудал, 55% нь төрийн бус өмчийн сургуульд сурагч сонгон элсүүлэх журмаас сэргийлэх, 27% нь ашиг олохыг хориглох, зөвхөн 7% нь эмзэг бүлгийн төлөөллийн хүртээмжийг дэмжихэд чиглэсэн квоттой байдаг. Улс орнуудын 48 хувьд нь хувийн хэвшлийн сургалтын ямар нэгэн зохицуулалтгүй харин 11 хувьд нь зөвхөн арилжааны хууль тогтоомжоор зохицуулагддаг.

Сургуулийн өмнөх боловсрол, техникийн болон мэргэжлийн, дээд, насанд хүрэгчдийн боловсролын дэд салбарт төрийн бус оролцогч талуудын оролцоо илүү өргөн байдаг.
Энэ нөхцөл байдал зарим тохиолдолд боловсролын салбарын тэгш байдал, чанарт нөлөөлдөг. Бага насны болон дээд боловсролын төрийн бус өмчийн байгууллагын төлбөр ерөнхийдөө өндөр байгаа нь төв, суурин газрын чинээлэг төлөөлөл дээрх байгууллагуудад ихээхэн төлөөлөлтэй болохыг харуулж байна. АНУ-д ашиг орлогоо нэмэгдүүлэх зорилготой их, дээд сургуулиудын оюутны сурлагын амжилт доройтож байгаатай шууд холбоотой байдаг. Түүнчлэн Австрали улсын ТМБС-ын ТӨЛБӨР-ТУСЛАМЖ зээлийн хөтөлбөр, Энэтхэг улсын Үндэсний ур чадвар хөгжүүлэх корпораци зэрэг зах зээлийн өрсөлдөөн болон ур чадвар хөгжүүлэх тогтолцоогоор хувийн хэвшлийн сургалт явуулдаг байгууллагууд хувийн хангамжийн чанарыг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн үр дүнг сайжруулах хариуцлага, хяналт-шинжилгээний үйл явцаа дахин хянан үзэж, сайжруулах шаардлага бий болсон.

Засгийн газар бүх боловсролын байгууллага, багш, сурагчдыг нэг бүхэл тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг гэж үзэх хэрэгтэй.
Стандарт, мэдээлэл, урамшуулал, ил тод байдал засгийн газруудад бүх нийтийн сурч боловсрох эрхийг хамгаалах, хүндлэх, биелүүлэхэд тусалж, эрх ямба, мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх учиртай. Улсаас санхүүжилттэй боловсролын үйлчилгээг олон нийтэд олгох албагүй, гэхдээ сургалтын явц, сурагчдын сурлагын үр дүн, багшийн ажлын нөхцөл дэх ялгаатай байдлыг эн тэргүүнд шийдвэрлэдэг байх ёстой. Инноваци, үр ашиг арилжааны нууц байх ёсгүй, эсэргээрээ тэднийг түгээж, бүх нийтээр хэрэгжүүлдэг байх ёстой. Энэ үр дүнд хүрэхэд төрөөс боловсролын талаар баримтлах бодлого ил тод, шударга байдлыг хангасан байх шаардлагатай.

Засгийн газрууд боловсролыг цаг үргэлж удирдан тэргүүлж байгаагүй. Түүхэнд, боловсролыг шашин, гэр бүл, дээд зиндааныхан албан бус байдлаар зохион байгуулж олгодог байсан. 18 дугаар зууны сүүлээс улс орнууд боловсролтой боловсон хүчний тусламжтайгаар эдийн засгаа хөгжүүлэх, улсын сургуулиар дамжуулан үндэсний онцлог байдлаа хөгжүүлэн бэхжүүлэх боломжийг олж харсан. Нийгэм, эдийн засагт илүү их өгөөж авчирч байгаа тул засгийн газрууд энэхүү олон нийтийн сайн сайханд зарцуулагдах өндөр зардлыг гаргахад бэлэн байсан. 20 дугаар зуунд шинээр тусгаар тогтносон орнуудын хувьд нийтийн боловсролын тогтолцоог бий болгох нь колоничлолоос ангижрах гол хүчин зүйл байв. Нийтийн боловсролын тогтолцоо үргэлж ёс суртахууны өндөр зарчим эсвэл захирах үзэл суртлыг дэмжих зорилготой байсан. Шинэ бүтэц нь уламжлалт боловсролын бүтцийг халж, уусгаж авсан.

Үүний зэрэгцээ, боловсрол хувь хүнд сайн сайхныг авчирдаг. Өндөр боловсрол эзэмших нь тухайн хүнд олдох боломжийг нэмэгдүүлж, магадгүй бусдыг энэ боломжоос хасах магадлалтай. Илүү өндөр боловсрол эзэмшиж чадсан хүмүүс амьдралын өндөр түвшинд хүрч, илүү их ашиг тусыг хүртдэг. Боловсролын тогтолцоо нь бүх хүмүүсийг өндөр боловсролоор хангах боломжгүй тул өрх айл бүр үр удмаа оргилд гаргахын тулд чадах бүхнээ хийдэг. Ийм өрсөлдөөн эрэлтийг бий болгож, улмаар боловсролтой холбоотой хэрэглээ, үйлчилгээний нийлүүлэлтийг бий болгодог. Тухайн орны нөхцөл байдал, хандлагаас хамааран давуу тал олгох боловсролын үйлчилгээг шууд хангах зах зээл шинээр үүсч болно.

НИЙТИЙН БОЛОВСРОЛД ҮЗҮҮЛЭХ ДЭМЖЛЭГ ӨНДӨР БАЙНА

Боловсролын сонголт нь хүүхдийн амьдралыг тодорхойлдог. Эцэг эхчүүд зөвхөн санхүүгийн зардал, үр ашгийн энгийн тооцоолол хийхээс гадна харилцан хамааралтай олон хүчин зүйлийг харгалзан үзэх ёстой. Юуг, хэрхэн, хэн, хаана заах нь өрсөлдөөнт дэлхийн хандлага болон эцэг эх болон боловсролын бусад оролцогч талуудын үзэл бодол, хүсэл эрмэлзлийг тусгасан байдаг. Тэдгээр нь хоёр үндсэн хэмжигдэхүүнийг авч үздэг: нөөцийг хянах, хуваарилах; болон нийгмийг өөрчлөх үнэ цэн, итгэл үнэмшил юм. Боловсролын талаарх сонголтууд нь улс төрийн шинж чанартай бөгөөд улс төрийн хөтөлбөрүүдэд шууд эсвэл далд хэлбэрээр тусгагдсан байдаг. Хувь хүний үзэл суртлын болон нөхцөл байдлын хүчин зүйлээс гадна нийгэмд түлгамдаж буй бэрхшээл, засгийн газар, хүмүүс, институциуд хоорондоо хэрхэн харилцах талаарх ойлголт улс орон бүрт харилцан адилгүй байдаг. Эдгээр ойлголтууд нь засгийн газар ямар бодлого баримтлах, түүнээс хэн ашиг хүртэх тухай хандлагад нөлөөлнө.

Бүх нийтийн боловсролыг дэмжих судалгааны дийлэнх нь өндөр орлоготой, хөгжилтэй орнуудад хийгдсэн байдаг. Дани, Франц, Герман, Ирланд, Итали, Испани, Швед, Их Британид саяхан хийгдсэн судалгаанд оролцогчдоос нэмэлт зардал гаргах боломжтой найман салбарын аль нэгийг нь чухалчлахыг хүсэхэд 28 хувь нь боловсролыг, 22 хувь нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сонгосон байна. Судалгаанд оролцогчдын 77 хувь нь сургууль гэсэн сонголтыг дэмжсэн бол 60 гаруй хувь нь хувийн сургуулиуд үндэсний боловсролын тогтолцоонд чухал үүрэг гүйцэтгэдэг гэсэн сонголтыг эсэргүүцсэн байна.

Энэхүү тайланд зориулан гаргасан Олон улсын нийгмийн судалгааны хөтөлбөр (ОУНСХ)-ийн засгийн газрын үүргийн талаарх тусгай модулийн өгөгдөлд хийсэн 2016 оны дүн шинжилгээ нь дунд орлоготой 10 орныг багтаасан 35 орны түүврийг ашиглан нийтийн боловсролын салбарын дэмжлэгийг авч үзсэн болно. Ерөнхийдөө, судалгаанд хамрагдсан насанд хүрэгчдийн 89 хувь нь сургуулийн боловсрол олгох үндсэн үүргийг засгийн газар, 6 хувь нь гэр бүл, 5 хувь нь бусад байгууллага (хувийн компани, ашгийн төлөө байгууллага; ашгийн бус байгууллага, буяны байгууллага, хоршоо; шашны байгууллагууд) хүлээх ёстой гэж хариулжээ. Гэтэл, төрийн бус оролцогч талуудад их санал өгсөн Энэтхэг (46%),[1] Филиппин (63%), Чили (76%) улс орнуудын судалгаанд оролцогчид төрийн хариуцах үүрэг гэсэн сонголтыг хамгийн бага дэмжсэн байна. **(Зураг 1).**

ОЛОН ТӨРЛИЙН МЭТГЭЛЦЭЭН ТӨРИЙН БУС ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ҮҮРГИЙН ТӨЛӨӨ ЭСВЭЛ ТҮҮНИЙ ЭСРЭГ БАЙР СУУРИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ ХҮРГЭЖ БАЙНА

Боловсрол дахь төрийн бус оролцогч талуудыг дэмжигчид болон эсэргүүцэгчид нь боловсролын салбарын үр ашиг, тэгш боломж, оролцоо, инновацийг хөхиүлэн дэмжих төрийн болон төрийн бус оролцогч талуудын чадавх, хууль ёсны байдлын талаар маргалддаг. Эдгээр асуудлыг авч үзэхдээ иргэд боловсролыг зах зээлээр дамжуулан худалдан авах бараа эсвэл үйлчилгээ хэмээн үзэж байгаа эсэх, боловсролыг сонгох боломжтой эсэхийг харгалзана.


Боловсролын салбарт төрийн бус оролцогч талууд зардлын хувьд үр ашигтай байдаг уу?
Боловсролын салбарт төрийн бус оролцогч талууд үйл ажиллагаа явуулахыг дэмжигчид нь боловсролын хэрэгцээг төрөөс бүрэн хангах боломжгүй тул төрийн бус оролцогч талуудын үйл ажиллагаа байх нь зайлшгүй гэж үздэг. Төрийн бус оролцогч талууд буяны үйлс, итгэл үнэмшил, үзэл санаа, ашиг хонжоо хайсан эсэхээс үл хамааран боловсролын бараа, үйлчилгээний нийлүүлэлт нь эрэлт хэрэгцээнд нийцэж байвал зах зээл бий болох боломжтой бөгөөд хэрэв нийцээгүй бол, ердийн зах зээл биш юмаа гэхэд ядаж төлөвлөгөөт зах зээл бий болно. Зах зээлээр дамжуулан зардлын үр ашигтай зорилгуудыг хэрэгжүүлэх боломжтой.

1 Төрийн бус оролцогч талуудын энэхүү бүс нутгийн тайлан нь Өмнөд Азид хамаарна.

ЗУРАГ 1:

Судалгаанд хамрагдсан улс орнуудын 80 гаруй хувь нь засгийн газар бүх нийтийн боловсрол олгохыг хариуцах ёстой гэж үздэг.

Сургуулийн боловсрол олгох үндсэн үүрэг төр засагт байна хэмээн үзсэн насанд хүрэгчдийн хувь,2016 он



Холбоос: https://bit.ly/GEM2021_Summary_fig1

Эх сурвалж: Эдланд ба Линдх 2016 оны Олон улсын нийгмийн судалгааны хөтөлбөрт үндэслэв (2021 он).

Боловсролын салбарт төрийн бус оролцогчдын үйл ажиллагааг эсэргүүцэгчид нь хэрвээ зардлын хувьд үр ашигтай байгаа бол тэднийг боловсролын тогтолцоо, туршлагад нэвтрүүлж, улсын болон хувийн хэвшлийн бүх сургуулиудад хэрэгжүүлэх ёстой хэмээн үздэг. Аль нэг улсын багш нар маш өндөр цалин авч байгаа бол энэ нь боловсролын үйлчилгээ хүргэх загвараа өөрчлөх үндэслэл биш, харин төрийн бодлогоор шийдвэрлэх асуудал байх ёстой. Төрийн бус оролцогч талууд залуу эсвэл чадваргүй багш нарыг ажиллуулах замаар зардлын үр ашгийг нэмэгдүүлэх боломжтой хэдий ч энэ нь тогтвортой шийдэл биш юм. Улсын болон хувийн хэвшлийн сургуулиудын зардлын үнэн зөв харьцуулалт хийх нь төвөгтэй байдаг. Улсын сургуулиуд нь боловсрол олгоход илүү зардал шаардахуйц боломж муутай иргэдэд үйлчилгээ үзүүлэх хандлагатай байдаг.

Төрийн бус оролцогч талууд боловсролд тэгш хамруулах боломж олгож байна уу?

Төрийн бус оролцогч талуудыг дэмжигчид төрийн бус үйлчилгээ үзүүлэгчид боловсрол эзэмших эрхийг хангахад тусалдаг хэмээн үздэг. Ихэнх нөхцөл байдалд, төрийн бус оролцогч талууд боловсролын үйлчилгээний бодит дутагдлыг нөхдөг бөгөөд энэ нь ихэнхдээ төрийн тогтолцоонд үл тоомсорлогддог эмзэг бүлгийнхэнд хүрдэг. Засгийн газрууд Пакистан улсын адил албан бус суурин газруудад сургууль байгуулах сонирхолгүй

байдаг. Төрийн бус оролцогч талууд нь 2015 онд Балбад тохиолдсон байгалийн гамшиг, газар хөдлөлт зэрэг хямрал,онцгой байдлын нөхцөлд үнэтэй хувь нэмэр оруулдаг. Эль-Сальвадор улсын хүчирхийлэл, бүлэглэлд нэрвэгдсэн хот суурин газруудад хувийн хувшлийн сургууль элсэгчдийн эзлэх хувь улсын дунджаас хоёр дахин их байна.

Хувийн хэвшлийн сургуулиудыг эсэргүүцэгчид сургуулийн сонголтоос үүдэн гардаг асуудлуудыг онцолдог. Хэрэв эцэг эхчүүд өөрсдийн хүссэн сургуулиа аливаа дүрэм журамгүйгээр сонгох боломжтой бол баячууд хамгийн сайн, ихэнхдээ хувийн хэвшлийн сургуулиудыг сонгох бөгөөд ингэснээрээ тэгш бус байдал, давхаргажилт, ялгаварлан тусгаарлалтыг улам даамжруулна. Эцэг эхийн шийдвэр гаргалтад сайн мэдээлэл шаардлагатай боловч сургуулийн онцлог шинж чанаруудын талаарх мэдээлэл дутмаг, эсвэл мэдээлэл байдаг ч эмзэг бүлгийн хүмүүст хүртээмжгүй, тэгш бус байдлаар түгээгддэг. Түүгээр ч зогсохгүй, үйлчилгээ үзүүлэхээс татгалзаж болзошгүй, хүрч ажиллахад бэрхшээлтэй хүн амын бүлгүүд ч байдаг.

Боловсрол олгоход засгийн газар үндсэн үүрэг гүйцэтгэх ёсгүй хэмээн үздэг зарим хүмүүс эрх баригчдын боловсролын агуулгыг шийдэх эсвэл хүссэн стандартын боловсрол олгох чадварыг нь эсэргүүцдэг. Орон нутгийн улсын сургууль нь хүүхдээ хүмүүжүүлэхийг хүсч буй соёл, үгсаатан, хэл шинжлэл, шашны нийгэмлэгийн үнэт зүйлд заналхийлж байна хэмээн санаа зовдог эцэг эхчүүд тусдаа хувийн хэвшлийн боловсролын үйлчилгээ авах сонголт хийдэг. Гэвч энэ нь тэгш, бүгдийг хамарсан боловсролыг хангах төрийн амлалттай зөрчилдөж, бүх хүүхдэд ижил чанартай боловсрол олгохын тулд нэгдсэн стандартыг хэрэгжүүлэхэд саад учруулж байна хэмээн засгийн газрууд эсэргүүцэх магадлалтай.

Төрийн бус оролцогч талууд боловсролд илүү шинэчлэл авчирдаг уу?

Боловсрол дахь төрийн бус оролцогч талуудыг дэмжигчид нь төрийн бус оролцоо нь инновацийг нэмэгдүүлэхэд тусалдаг гэж үздэг. Сурган хүмүүжүүлэх ухааны талаарх ойлголтыг өөрчилсөн олон үзэл санаа нь нийтийн боловсролын тогтолцооны хүрээнд болон гадна орчноос ч гарч ирсэн байдаг. Нийтийн боловсролын тогтолцоо нь хүрч үйлчлэх ёстой хүн амынхаа үзэл бодлыг үл тоомсорлож чадахуйц томоохон, төвлөрсөн хүнд суртал болтлоо өргөжсөн. Уг тогтолцоо нь санаачилгыг мохоон, стандартчилалыг албадаж, сурагч, багш нарын урам зоригийг бууруулдаг гэсэн нийтлэг шүүмжлэл байдаг.

Инновацийг нэвтрүүлэх нь нийтийн боловсролын тогтолцооны үүрэг юм. Өөрчлөлтүүдийг турших,өргөжих чадварыг нь шалгах шаардлагатай байдаг. Үүнд хүнд суртлын саад бэрхшээл, байгууллагын чадавхын зөрүү, багш, эцэг эхийн урам зориг дутмаг байдал, санхүүгийн хязгаарлагдмал боломж,улс төрийн оролцоо,эсэргүүцэл зэрэг саад бэрхшээл тулгарч болно. Гэсэн хэдий ч нийтийн боловсролын тогтолцоо нь загвар бүтцийнхээ хувьд инновацид сөргөөр нөлөөлдөггүй. Мөн төрийн бус зарим оролцогчид нийтийн боловсролын тогтолцоонд тодорхой инновациуд ажиллаж болох боломжийг судалж байна.

Инновацийн талаарх мэтгэлцээн гол ухагдахуунуудыг эсрэг тэсрэг байдлаар иш татсанаас болж тодорхой бус байдалд хүрсэн байдаг. Стандартчилал нь нийтийн боловсролын тогтолцоог уян хатан бус, хууль журмыг дагаж мөрддөг, ялгаваргүй байдал гэж үзэн эсэргүүцдэг хүмүүсээр үгүйсгэгдэж байгаа ч бүх сургуулиудад стандартыг хангасан байхын тулд нийтлэг цөм хөтөлбөрийг дэмжигчид болон ихэвчлэн хувийн хэвшлийн үйлчилгээ үзүүлэгчдийн нөлөөгөөр өрсөлдөөнт дарамт гэж үзэн стандартыг дагаж мөрдөх хандлагыг хурдасгадаг гэж боддог хүмүүсээр дэмжигдэж байна. Эцсийн эцэст, стандартчилал нь инновацийг сааруулах эсэх нь ямар стандартыг тогтоосноос хамаарна. “Хариуцлага”, “бие даасан байдал”, “сонголт” гэх мэт нэр томьёо нь боловсролын байгууллагын зарчимд тусгагдсан ч бууруушаагдаж байдаг. Эдгээр санаануудын аль нэгийг давуу талаас нь шалгаж үзэх боломжтой боловч төрийн бус, ялангуяа хувийн боловсролын үйлчилгээний томоохон үүргийг зөвтгөх албагүй.

БОЛОВСРОЛ ДАХЬ ТӨРИЙН БОЛОН ТӨРИЙН БУС ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ТУХАЙ ЦУУ ЯРИА

Энэхүү тайланд боловсрол дахь төрийн болон төрийн бус оролцогч талуудын тухай яригддаг 10 цуу яриаг хэлэлцэх болно.

Цуу яриа 1.


Төрийн болон төрийн бус оролцогч талуудыг тодорхой ялгаж салгах боломжтой.



Боловсрол дахь төрийн бус оролцогчдын тухай хэлэлцүүлэг нь ихэвчлэн улсын болон хувийн хэвшлийн сургууль гэсэн хоёр хэсэгт ангилагддаг. Бодит байдал дээр энэхүү зураглал нь илүү төвөгтэй бөгөөд ялгаанууд нь тодорхой бус байдаг. Төрийн бус оролцогч талууд олон янз байдаг. Тэд боловсролын салбарт үзэл бодол, үнэт зүйл, итгэл үнэмшил, сонирхлын янз бүрийн шалтгааны улмаас орж ирдэг. Олонхи нь засгийн газартай гэрээ байгуулах, төр, хувийн хэвшлийн түншлэл зэрэг албан болон албан бус зохион байгуулалтын хэлбэртэйгээр орж ирдэг бөгөөд энэ нь ялгааны заагийг бүдэгрүүлдэг.

Цуу яриа 2.

Өмчлөл ямар хэмжээнд байгаа нь тодорхой байдаг.



Төрийн бус оролцогч талуудын үүрэг оролцоог тодорхойлоход нийт элсэлтэд хувийн байгууллагуудын эзлэх хувь хэмжээнээс хамаардаг. Сурагчдад хичээлийн дараа нэмэлт хичээл заах орлогоо олдог улсын сургуулийн багш нарыг улс орнууд хэрхэн тооцдог вэ? Сурах бичиг, үнэлгээ эсвэл өгөгдлийн удирдлага, тэр байтугай хоолны үйлчилгээ, тээвэр зэргийг гадаад эх үүсвэрээр бий болгодог боловсролын тогтолцоо нь хэрхэн төрийнх байх вэ? Лоббидогчийн боловсруулсан төрийн бодлого одоог хүртэл төрийнхөд тооцогдож байна уу?

Цуу яриа 3.


Боловсролын хувьчлалд хувийн хэвшил бууруутай.



Хувийн хэвшлийн үйлчилгээ эрхлэгчдийн дийлэнх нь нэг хүний эзэмшлийн сургуулиуд байдаг. Үл ойшоосны улмаас улсын сургуулийн чанар буурсантай холбоотойгоор эцэг эхчүүдийн санаа зовнилын хариуд тэд бий болсон юм. Чанар буурсан нь тодорхой болох үед чинээлэг, түүнчлэн зарим бууралт өрхүүд төрийн тогтолцоог орхисноор дэмжлэгийг нь сулруулж, санхүүжилт багасахад хүргэсэн. Улс төрийн удирдагчдын дундах элит үзэл нь тэдний тэгш бус байдлыг тэсвэрлэх чадварыг нэмэгдүүлж, төрийн боловсрол, түүнээс ашиг хүртэж буй бололцоо муутай хүн амыг хамгаалах хүсэл эрмэлзлэлийг бууруулсан.

Цуу яриа 4.


Нийтийн боловсрол тэгш байдлыг хангасан.



Айл өрхүүд далд төлбөр,зайлсхийх боломжтой төлбөр, нэмэлт зардал болон олон нийтэд нөхөн олговор олгох нэмэлт зардал зэрэг улсын сургуулиуд санал болгодоггүй өндөр зардал төлдөг. Төрийн бус үйлчилгээ үзүүлэгчдэд үүд хаалгаа нээж өгсөн боловсролын тогтолцоог шүүмжлэх нь нийтлэг байдаг бөгөөд энэ нь тэгш бус байдлыг улам хурцатгаж байдаг ч нийтийн боловсролын олон тогтолцоо нь давхаргажилт, ялгаварлан тусгаарлалтаас сэргийлж чаддаггүй.

Цуу яриа 5.

Эцэг эхчүүд сургууль сонгохдоо чанарын талаарх баттай мэдээлэлд үндэслэдэг



Хувийн хэвшлийн сургууль болон сургуулийн сонголтыг дэмжигчдийн үндсэн таамаглал бол хэрэглэгчдийн хувьд эцэг эхчүүд нь шилдэг сургуулиудын талаарх мэдээлэлд хүртээмжтэй байдаг бөгөөд түүнийгээ үр дүнтэй ашиглах явдал юм. Бодит байдал дээр,сургуулиудын үр дүнгийн талаарх мэдээлэл нь ихэнх улс оронд удирдаж, харилцан мэдээлэхэд хэтэрхий төвөгтэй байдаг. Мөн, ийм мэдээллийг үл тоомсорлон эцэг эхчүүд нь шашны итгэл үнэмшил, тав тухтай байдал, сурагчдын хүн ам зүйн онцлог зэрэг шалтгаанаар өөрсдөд нь таалагдах сургуулийг сонгодог.

Цуу яриа 6.

Өрсөлдөөн сургуулийг сайжруулахад хүргэдэг.



Хариуцлагатай, эрүүл өрсөлдөөн зарим хүмүүсийг сайжрахад нь түлхэц болдог. Эдийн засгийн салбарт, ашиг олох нь тэдний оршин тогтнох шалтгаан болдог тул компаниуд оршин тогтнохын тулд өрсөлддөг. Гэхдээ боловсролын салбарт ийм динамик хэрхэн нөлөөлж байгаа нь тодорхойгүй байна. Тогтолцооны хэмжээнд өрсөлдөөний үр нөлөөг харуулсан судалгаанууд нь сэдвийн нарийн төвөгтэй байдлаас шалтгаалан ховор байдаг бөгөөд үр дүн нь тодорхойгүй байдаг. Хамгийн муу нь, өрсөлдөөн нь хувийн хувшлийн сургуулиудыг сурган хүмүүжүүлэх сайн туршлагын эсрэг, эцэг эхийн хүсэл эрмэлзэл рүү хөтлөхөд хүргэдэг.

Цуу яриа 7.

Хувийн хэвшлийн сургууль болон их, дээд сургуулиуд илүү сайн.



Хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэгддэг,сургуулиудыг хүснэгтээр харьцуулсан хувийн хэвшлийн сургуулиудын шалгалтын тэнцлийн хувь хэмжээний харьцуулалт нь ердийн нотолгоо бөгөөд үүнийг эцэг эхчүүд их уншдаг. Үнэн хэрэгтээ, суралцагсдын элсэлт олон янз ба боловсрол сайтай,хүсэл эрмэлзэл өндөртэй эцэг эхчүүд хувийн сургуулийг сонгох магадлал өндөр байдаг. Хувийн сургуулиуд нь эргээд сайн үр дүнд хүрэхийн тулд сурагчдыг шалгаж авдаг. Ийм хүчин зүйлсийг хянаж чадвал улсын болон хувийн сургуулиудын хоорондын ялгаа багасч эсвэл арилдаг байна.

Цуу яриа 8.


Хувийн хэвшил бол сургуулиас гадуурх хүүхдүүдийн асуудлыг шийдэх шийдэл юм.



Бага, дунд сургуулийн 350 сая гаруй сурагч хувийн хэвшлийн сургуульд суралцаж байгаа тул эдгээр сурагчид нийтийн боловсролын тогтолцоонд шилжвэл зайлшгүй хямрал нүүрлэх болно. Гэсэн хэдий ч, хувийн сургуулиудын элсэлт хот суурин газруудад эрс нэмэгдэж элсэлтийн түвшин улсын сургуулийнхтай ойртсон байна. Харин хөдөө орон нутагт хувийн хэвшлийн сургуулиуд бараг байдаггүй. Мөн бага,дунд орлоготой улс орнуудад хамгийн чинээлэг өрхийн 20 хувь нь хүүхдүүдээ хувийн сургуульд суралцуулах магадлал нь хамгийн ядуу өрхийн 20 хувь дахь үе тэнгийнхнээсээ 10 дахин их байдаг.

Цуу яриа 9.

Хувийн хэвшил бол боловсролын санхүүжилтийн цоорхойг нөхөх шийдэл юм.



Хувийн хэвшлийнхэнд ТХЗ 4-т хүрэхэд туслах боловсролын санхүүжилтэд чухал үүрэг гүйцэтгэнэ гэсэн өндөр найдвар байнга хүлээлгэдэг. Одоогоор үүнийг биелүүлэх хүсэлтэй эсвэл чадвартай гэсэн нотолгоо байхгүй. Гэхдээ хувь нэмэр оруулах өөр боломжууд бий, жишээ нь, татвар. Ялангуяа, бага, бага-дунд орлоготой улс орнуудын хувьд дотоодын орлогыг төвлөрүүлэх хувь хэмжээ бага, татвараас зайлсхийх боломж их байдаг тул татвар чухал юм. Хувийн хэвшил нь үндэсний дүрэм журмын дагуу хүүхдийн ур чадварыг хөгжүүлэх, хүүхэд асрах үйлчилгээнд илүү хүчтэй манлайлах боломжтой.

Цуу яриа 10.

Төрийн хууль эрх зүйн зохицуулалт нь төрийн бус оролцогчидтой холбоотой бүх асуудлыг шийдэж чадна.



Боловсрол дахь төрийн бус үйл ажиллагааг зохицуулах ёстой гэдэгтэй санал нэг байна. Гэвч дүрэм журам нь тэгш боломж, чанарыг тогтолцооны хэмжээнд хэрхэн дэмжих талаар дорвитой тусгаагүй байдаг. Чинээлэг өрхүүд хувийн сургууль руу зүтгэх нь боловсролын тогтолцоог тусгаарлан хуваж байна уу, эсвэл өрхийн боловсролын зарцуулалт тэгш бус байдлыг хэрхэн нэмэгдүүлж байна вэ гэдгийг цөөн тооны засгийн газар хянадаг. Олон улс орны засгийн газрууд сургуульд сонгон элсүүлэхийг зөвшөөрдөг. Түншлэл нэрийн дор үндсэндээ тодорхойгүй хэвээр байгаа хувийн нэмэлт сургалтын төлбөр эсвэл лоббиг зохицуулдаг улс орнууд цөөхөн байдаг. Дүрэм журмыг үр дүнтэй хэрэгжүүлэх, мөрдүүлэх нөөц бололцоо бүр ч цөөн улс оронд бий.

Одоогоос 25 жилийн өмнө АНУ-д сургуулийн сонголт дээр үндэслэсэн нийтийн боловсролын шинэ зохион байгуулалтын хэлбэрүүд тэгш бус үр дагавартайг нотлох баримтууд гарч ирэхэд өмнөх судалгааны зохиогчид үр дүнг хоёр асуултаар тэр дор нь нэгтгэн дүгнэжээ: Хэн сонгох вэ? хэн алдах вэ? (Фюллер ба Эльмор, 1996 он). Дэлхий даяар сургууль сонгох үйл явц, үр нөлөө, үр дагаврын талаар илүү олон нотолгоо хуримтлагдаж байгаа тул Боловсролын хяналт-шинжилгээний дэлхийн тайлан нь эдгээр асуултуудыг дэлхий даяарх хүлээн авагчдад хүргэж байна. Бага, дунд боловсролд төрийн бус үйл ажиллагааны дөрвөн гол асуудал болох хангамж, зохицуулалт, санхүүжилт, үр нөлөөг авч үзсэн бөгөөд үүний дараа бага анхаарал хандуулдаг бусад боловсролын түвшинд илүү гүнзгийрүүлэн судалсан ба үүнд сургуулийн өмнөх боловсрол, дээд боловсрол, техникийн, мэргэжлийн болон насанд хүрэгчдийн боловсрол орно.

ХАНГАМЖ

Хувийн хэвшлийн сургуульд элсэгчдийн тоо нэмэгдсээр байна. Дэлхий даяар хувийн хэвшлийн боловсролын байгууллагын эзлэх хувь 10 орчим жилийн дотор 7 хувиар нэмэгдэж, бага боловсролд 2002 онд 10 хувь байсан бол 2013 онд 17 хувь, дунд боловсролд 2004 онд 19 хувь байсан бол 2014 онд 26 хувь болж өссөн боловч түүнээс хойш бараг өөрчлөгдөөгүй хэвээр байна. **(Зураг 2).**


Өмчлөл, удирдлага, санхүүжилт нь төрийн бус салбарыг тодорхойлох энгийн шалгуур юм. Үйлчилгээ үзүүлэгчдийн төртэй харилцах харилцаа, тэдний хүсэл эрмэлзэл, үнэ төлбөр зэргийг тэднийг бүлэглэж ангилахад ашиглаж болно. Энэхүү тайланд хийгдсэн шинжилгээ нь дэлхийн 196 орны 124-т нь итгэл үнэмшилд суурилсан сургуулиуд байгааг тодорхойлсон бол төрийн бус байгууллага (ТББ) болон олон нийтийн сургуулиуд 196 орны 74-т нь голдуу онцгой байдлын нөхцөлтэйгөөр үйл ажиллагаа явуулж байна. Арабын Нэгдсэн Эмират зэрэг цөөн хэдэн нөхцөл байдлаас бусад тохиолдолд ашгийн төлөөх сургуулиуд цөөн байна. Сахарын цөлөөс өмнө бүсийн Африк, Азийн бага, дунд орлоготой орнуудын дунд зэргийн үнэтэй, ихэвчлэн ганц өмчлөгчтэй сургуулиудыг бага төлбөртэй хувийн сургуулиуд гэж нэрлэдэг.

Улсын болон хувийн хэвшлийн сургуулиуд нь сурагчдын тоо, нөөцөөр ялгаатай байдаг. Ядуу өрхийн хүүхдүүдийн цөөхөн хувь нь хувийн сургуульд сурах боломжтой байдаг. Боловсролын туршлагын чанарыг үнэлэхийн тулд эцэг эхчүүд сурагчдын тоо, багшийн чанар, хичээл зүтгэл, сургуулийн хариу үйлдэл, сахилга бат, аюулгүй байдал, сургалтын хэл, шашин шүтлэг, үндэс угсаа, соёл зэргийг харгалзан үздэг. Их Британид нийт 18,000 англи сургуульд улсын сургуулиудыг хувийн хэвшлийн удирддаг улсын сургуулиудтай харьцуулж үзэхэд сүүлийн үед мэргэшээгүй багш нар илүү их хувийг эзэлж байгаа нь дүн шинжилгээгээр тодорхойлогдсон. Улсын болон хувийн хэвшлийн сургуулиуд бусад нөөцийн хувьд ялгаатай байж болно.

ЗУРАГ 2:

Хувийн сургуульд элсэгчдийн хувь Өмнөд Азид хамгийн өндөр байна.

Хувийн хэвшлийн боловсролын байгууллагад элсэгчдийн хувь, боловсролын түвшингээр, 1990–2019 он



Эх сурвалж: ЮНЕСКО-ийн Статистикийн хүрээлэнгийн өгөгдлийн сан

Латин Америкт хувийн сургуулиудын нэг сурагчид ногдох компьютерийн дундаж тоо улсын сургуулийнхаас хоёр дахин их байдаг.

Хувийн сургуульд суралцахын давуу тал хязгаарлагдмал гэдгийг ихэнх нотолгоо харуулж байна.
Бага, дунд орлоготой 31 орны тоо баримтаас харахад өрхийн хөрөнгөнд тохируулга хийж үзэхэд хувийн сургуульд сурсны үр ашиг нь тал хувиас гуравны хоёр хүртэл буурсан байна. Түүгээр ч зогсохгүй хувийн хэвшлээр суурь боловсрол олгох нь богино болон дунд хугацаанд дутагдал, ялгааг нөхөж болох ч энэ нь ялгаварлан тусгаарлалт, тэгш бус байдалд хүргэж болзошгүй юм. Шведэд 30 хотын захиргааны 29 нь бага дунд сургуулийн түвшинд ихээхэн хэмжээний тусгаарлалттай байсан бол 16-д нь энэхүү тусгай байдал нь сургуулийн сонголтоос ихээхэн шалтгаалсан байна. Хувийн хэвшлийн сургуулиудтай өрсөлдөх нь улсын сургуулиудыг сайжруулахад түлхэц болох төлөвтэй байгаа ч хувийн болон бусад сургуулиуд ойролцоо байх нь санхүүгийн эх үүсвэр эсвэл хариу арга хэмжээ авах бие даасан байдал байхгүй тохиолдолд төрийн сургуулийн удирдлагуудад үүнийг шийдвэрлэхэд хангалттай түлхэц болж чадахгүй.

Хувийн нэмэлт сургалтын төлбөр бараг бүх нийтийнх байдаг.
Зүүн Азийн зарим улс, Арабын орнуудад тархсан энэ үзэгдэл Сахарын цөлөөс өмнө бүсийн Африк, хойд Европ зэрэг бүс нутагт ч тархаж байна. Нэмэлт сургалтын төлбөрийн эрэлт нь сурагчдын өрсөлдөөнт давуу талыг олж авахын тулд өндөр бооцоотой шалгалтад бэлтгэх хэрэгцээтэй холбоотой. Гэхдээ тухайн сурагчийн гүйцэтгэлд үзүүлэх сургалтын үр нөлөө нь янз бүр байдаг. Зарим судалгаанаас харахад хамгийн их хоцрогдолтой сурагчдад эерэг нөлөө үзүүлсэн бол бусад судалгаанууд нэмэлт давтлага нь сурагчийн гүйцэтгэлд системчилсэн эерэг нөлөө үзүүлдэггүйг харуулж байна. Түүнчлэн, нэмэлт давтлага нь сурагч, багшийн зан төлөвт сөргөөр нөлөөлж ингэснээр боловсролын тогтолцооны гүйцэтгэлийг сулруулж байна.

Сурах бичгийн бодлого, худалдан авалт, түгээлт нь төрийн оролцооноос хамааран харилцан адилгүй байдаг. Зарим улс оронд хэвлэлийн ажлыг үндсэндээ төрийн өмчит болон төрийн хяналтат аж ахуйн нэгжүүд хийдэг бол бусад оронд төрийн болон хувийн хэвшлийн холимог тогтолцоотой байдаг. Испани зэрэг өндөр орлоготой улс орнууд сурах бичгийн үйлдвэрлэлийг арилжааны байгууллагуудад даатгаж, удирдамжаар хангах, төслийг батлахад засгийн газар оролцдог. Олон улсын хэвлэлийн компаниуд, хандивлагч байгууллагууд болон орон нутгийн ашиг сонирхол хоорондын харилцан үйлчлэл нь буурай орнуудад орон нутгийн хэвлэлд шилжихэд хүндрэл учруулдаг. Жишээлбэл, Габоны сурах бичгийн салбарт дэлхийн хамгийн том хэвлэлийн газруудын нэг болох Франц улсын эзэмшдэг Хашет Ливрийн сурах бичиг хэвлэх салбар Эдисеф давамгайлж байна.

Контентыг дижитал болгох ажлыг томоохон хэвлэлийн болон технологийн компаниуд удирдаж байна. Боловсролын хэвлэлийн дэлхийн зах зээлд тэргүүлэгч Пирсон "Дэлхийн хамгийн том сурах бичиг, онлайн сургалтын материал хэвлэн нийтлэгч" гэсэн уриагаа "дэлхийн дижитал суралцахуйн компани" болгон өөрчилж, онлайн сургалт, үнэлгээнд илүү анхаарч эхэлсэн. Дэлхийн болон бүс нутгийн сурах бичиг хэвлэгчдээс гадна технологийн аваргууд онлайн боловсролын салбарт орж ирэх чиг хандлага нь КОВИД-19 цар тахлын үеэр илүү бэхэжсэн. АНУ-ын боловсролын технологийн худалдан авалтын үйл явцын туршлагад дүн шинжилгээ хийхэд сургуулийн дүүрэг, сургуулиуд ихэвчлэн олон төрлийн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлдэг олон мянган боловсролын технологийн борлуулагчдад дарагддаг болохыг тогтоожээ.

Засгийн газрууд боловсролын салбарт илүү их гадны эх үүсвэрийг эрэлхийлж байна. Аутсорсинг буюу гадны эх үүсвэрийг шүүмжлэгчид хувьчлал нь төрийн үйлчилгээ, мэргэжлийн ур чадварыг алдагдуулж болзошгүй хэмээн эмээж байна. Австрали улсын судалгаагаар цэвэрлэгээний ажилтны гэрээ нэмэгдэх нь гэрээт гүйцэтгэгчдийн тоо олширч, дутуу цалин авах тохиолдол нэмэгдэж, цэвэрлэгээ хийх цаг багасч, хөдөлмөр эрхлэлтийн эрүүл мэнд, аюулгүй байдлын стандартыг бууруулдаг болохыг тогтоожээ.

ЗАСАГЛАЛ БА ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Төрийн бус боловсролын байгууллагуудын засаглал нь ихэвчлэн хуваагдмал байдаг. Сайн засаглал, үр дүнтэй эрх зүйн зохицуулалт нь засгийн газруудын чанартай боловсролыг тэгш хүртээх чадварыг тодорхойлох гол хүчин зүйл юм. Дэлхийн 94 улс орны салбарын төлөвлөгөө эсвэл стратеги нь хангамж болон бусад үйлчилгээ үзүүлэхэд төрийн бус оролцогч талуудыг оролцохыг тусгасан байдаг. Зарим улс оронд яам, газрууд нь үүрэг хариуцлагаа хуваалцдаг. Хуваагдал, зохицуулалтын дутмаг байдал, үүрэг хариуцлагын давхцал эсвэл тодорхой бус илэрхийлэл нь тэгш боломж, чанарт сөргөөр нөлөөлдөг. Улс орнуудын ердөө 39 хувь нь төрийн бус боловсролын байгууллагын хэлтэс, агентлаг эсвэл газартай байж үндэсний хэмжээнд бага, дунд боловсролыг хариуцдаг байна. Харин, улс орнуудын 83 хувьд боловсролын яам нь төрийн бус боловсролын байгууллагуудын үйлчилгээний чанарыг онцгойлон хариуцдаг бол 13 хувьд нь янз бүрийн албад, байгууллагууд хариуцдаг. Улс орнуудын 22 хувь, Хойд Африк, Баруун Азийн 70 хувьд нь боловсролын яам гэхээсээ илүүтэй шашны хэрэг эрхлэх газар нь шашинд суурилсан сургуулиудыг хариуцдаг.

Санхүүжилтийн механизм нь засаглалд нөлөөлдөг.
Төрийн бус оролцогч талууд төрөөс шууд болон шууд бус санхүүгийн дэмжлэгийг янз бүрийн хэлбэрээр авдаг: нэг сурагчид ногдох тэтгэмж (улс орнуудын 79% нь), эцэг эхэд олгох тэтгэмж (23%), багшийн цалин эсвэл бусад үйл ажиллагаанд үзүүлэх дэмжлэг (70% орчим), зээл эсвэл бэлэг (27%). Төр, хувийн хэвшлийн түншлэл нь оролцогч бүрийн хоорондын янз бүрийн түвшний оролцоо, олон төрлийн бодлого, зохицуулалтыг хамардаг. Санхүүжилтийн механизмын талаарх

судалгааг тоймлон үзэхэд үр нөлөө нь ихэвчлэн сөрөг байна. 98 судалгааны дор хаяж гуравны хоёрт нь тэтгэмж, ваучерын хөтөлбөр, тэтгэлгийн хөтөлбөрүүдийн тэгш боломжид үзүүлэх нөлөөлөл сөрөг байна.

Зохицуулалт нь боловсролын чанар, тэгш боломжийг сайжруулахад туслах ёстой. Бараг бүх улс орнууд хувийн хэвшлийн сургуульд элсэх, ажиллуулахад тавигдах шаардлага, тэр дундаа бүртгэл, тусгай зөвшөөрөл зэргийг тусгасан журамтай байдаг. Улс орнуудын 80 хувьд талбай, барилгын хэмжээ, анги танхимын хамгийн бага зай зэрэг орон зайд тавигдах шаардлагуудын зохицуулалт байдаг. Энэтхэгийн Харьяна мужид сургууль байгуулахын тулд барилга байгууламжийг дор хаяж 20 жил эзэмшиж эсвэл түрээслэх шаардлагатай. Өөр нэг муж болох Уттар Прадеш нь сургуулийг хүлээн зөвшөөрөх хоёр шалгуурыг тавьдаг: нэг сурагчид ногдох хамгийн бага талбай (9м2) ба анги танхимын хэмжээ (180м2). Эрх зүйн зохицуулалтад мөн ус, эрүүл ахуй хамаарна. Өгөгдөл бүхий улс орнуудын 47 хувьд хувийн сургуулиудад нэг хүйсийн бие засах газартай байхыг шаардсан байдаг. Улс орнуудын 74 хувьд сурагч, багшийн харьцааг зохицуулдаг. Улс орнуудын 45 орчим хувь нь хувийн сургуулийн элсэлтийн журамтай холбоотой зохицуулалттай байдаг бол 67 хувь нь албан боловсролын хувийн сургуулийн төлбөрийг эрх зүйн баримт бичигт тусгасан байдаг. Улс орнуудын гуравны хоёр нь сургалтын хөтөлбөрийн журамтай байдаг. Сүүлийн 10 жилийн хугацаанд 21 улс орон ашиг орлого олох, 80 улс орон багшийн гэрчилгээ олгох журам гаргажээ.

Сул хэрэгжилт, хангалтгүй хариуцлага боловсролын чанар, тэгш боломжийг алдагдуулж байна. Дүрэм журамтай байх нь төрийн бус үйлчилгээ үзүүлэгчид дагаж мөрддөг гэсэн үг биш юм. Зарим бага, дундаас доош орлоготой орнуудад нарийн төвөгтэй, өндөр өртөгтэй эсвэл удаан хугацаа шаарддаг бүртгэлийн журам нь үйлчилгээ үзүүлэгчдийг албан ёсоор хүлээн зөвшөөрөгдөхөд саад болдог. Нигер улсын Лагос мужийн захиргаа 2021 оны байдлаар 20,000 орчим хувийн сургуулийн дөрөвний нэгийг нь л баталсан байна. Дор хаяж 27 улс орны статистик мэдээлэл нь бүртгэлгүй сургуулиуд байгааг илэрхийлж байна. Уганда улс төрийн бус сургуулиудыг тусгай зөвшөөрөлтэй, бүртгэлтэй, бүртгэлгүй гэж ангилдаг ба үүнд бага сургуулийн 14 хувь, дунд сургуулийн 13 хувь нь бүртгэлгүй байна. Хяналт дутмаг байх нь сурагчдыг албан бусаар сонгоход хүргэдэг. Колумбын Богота хотод эмзэг бүлгийн сурагчдад үйлчлэх зорилгоор байгуулагдсан Концессын сургуулийн хөтөлбөр нь ялгаварлан гадуурхахгүй байх, оршин суух газартай ойр байх зэрэгт суурилсан элсэлтийн бодлоготой байсан хэдий ч бодит байдал дээр албан бус ч гэсэн сурагчдыг сурлагын гүйцэтгэлээр нь сонгосон байв.

Чанарын баталгаажуулалтын үйл явц, стандартууд өөр өөр байдаг.
Бараг бүх улс оронд сургуулийн шалгалтаар хувийн сургуульд стандартыг мөрдүүлдэг. Улс орнуудын 81 хувь нь хувийн хэвшлийн бүх төрлийн сургуулиудад энэ үүрэг хамаардаг бол 3 хувьд нь зөвхөн засгийн газрын тусламжтай сургуулиудад хамаарна. Түүнчлэн улс орнуудын 81 хувь нь томоохон хэмжээний үнэлгээнд хувийн сургуулиудыг оролцуулах зохицуулалттай байдаг. Эдгээр улс орнуудын талаас илүүд нь бүх төрлийн хувийн сургуулиуд энэхүү үүрэг хариуцлагыг хүлээдэг бол 12 хувьд нь зөвхөн засгийн газрын тусламжтай сургуулиудад хамаарна.

Үр дүнтэй хариуцлагын механизм, хориг арга хэмжээ, залруулах механизмууд нь хууль журмыг дагаж мөрдөхөд түлхэц болно. Чанар, орц, аюулгүй байдал, хүртээмжийн стандартыг дагаж мөрдөхөд нь Засгийн газар боловсролын байгууллагуудад хариуцлага тооцох ёстой. Хувийн сургуулиуд дүрэм журмыг дагаж мөрдөөгүй тохиолдолд бараг бүх улс орнууд хориг арга хэмжээ авах, сургуулийг хаах эсвэл лицензийг нь цуцлах арга хэмжээ авдаг. Улс орнуудын 54 орчим хувь нь ийм төрлийн хаалтын хугацааг мөн зохицуулдаг. Дэлхийн 90 орчим улс оронд багш, сургуулийн ажилтнуудад зориулсан ёс зүйн дүрэм байдаг бөгөөд үүнд төрийн бус үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд ихэвчлэн хамаардаг.

Хувийн нэмэлт сургалтын зохицуулалт ховор байдаг. Улс орнуудын 48 хувьд хувиараа хичээл заах тухай зохицуулалт байдаггүй. Зөвхөн 53 улс үүнийг боловсролын тухай хууль тогтоомжоор зохицуулдаг бол 19 улс зөвхөн арилжааны хуулиар зохицуулдаг байна. Улс орнуудын 31 хувьд гэрийн багшийн шаардагдах ур чадварыг журамд заасан байдаг бол 10 улс орон багш нарыг давтлага хичээл заахыг шууд хориглодог. БНХАУ-ын 2021 оны хуулиар албан боловсролын сургалтын хөтөлбөрийг заадаг пүүсүүдэд ашиг олох, мөн хөрөнгө босгохыг хориглож, шинээр лиценз олгохыг хорилгожээ. Компаниуд үйл ажиллагаагаа үргэлжлүүлэхийн тулд ашгийн бус болох хэрэгтэй болсон. Засгийн газраас хувийн сургалтын компаниудын үйл ажиллагааг зохицуулах, хянах тусгай алба байгуулсан.

САНХҮҮ

Засгийн газар төрийн бус үйлчилгээ үзүүлэгчдийг хэрхэн санхүүжүүлэх, мөн санхүүжүүлэх эсэх талаар шийдвэр гаргахдаа харилцан адилгүй байдаг. Канад улсад хувийн хэвшлийн сургуулийн зардлын 30 хувийг, улсын сургуулийн зардлын 94 хувийг засгийн газар хариуцдаг. Нидерланд улсад төрлөөс үл хамааран бүх сургуулиудад ажилтнууд болон үйл ажиллагааны зардалд зориулж тэтгэлэг өгдөг харин нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал тааруу, тусгай боловсролын хэрэгцээтэй сурагчдад зориулж нэмэлт санхүүжилт олгодог. 2000 оноос эхлэн Чили, Унгар, Швед, Их Британи зэрэг хэд хэдэн улсуудад засгийн газраас санхүүжилтийнхээ 50-иас доошгүй хувийг авдаг элсэлтийн хувь хувийн хэвшлийн сургуулиудад нэмэгдэж байна.

Засгийн газар хувийн хэвшлийн сургуулийн зөвхөн зарим зардлыг санхүүжүүлдэг. Бангладеш улсад нийт сурагчдын 96 хувь хичээллэдэг 16,000 гаруй хувийн дунд сургууль, 7,600 Исламын сургалтын коллеж буюу мадраса нь багшийн цалингийн төлбөрийг сар бүр авдаг. Харин бага сургуулийн 85 хувь нь төрийн бус харьяалалтай байдаг Гаити улс цалингийн

зардлыг хариуцдаггүй. Энэтхэг улсад 2019/20 онд бага, дунд сургуулийн ердөө 6 хувь нь багшийн цалингийн буцалтгүй тусламж авчээ. Индонези улсад нийт хувийн сургуулиудын 35 хувийг эзэлдэг песантрен гэгддэг мадраса болон исламын дотуур байртай сургуулиудыг санхүүжилтийн зарим механизмаас хассан байна.

Зарим засгийн газар хувийн хэвшлийн сургуулиудад эмзэг бүлгийн сурагчдыг элсүүлэхийг дэмждэг. Энэтхэг улсад 2009 оны Боловсролын эрхийн тухай тогтоолоор хувийн сургуулиуд 1-р ангийн 25 хувийг орлого багатай өрхийн хүүхдүүдэд олгохыг шаарддаг бөгөөд хариуд нь засгийн газраас сургалтын төлбөрийг нөхөн төлдөг байна. Үүний эсрэгээр, 2010/11 болон 2017/18 оны хооронд хахууль өгдөг ерөнхий боловсролын сургуулиудын сурагчдын тоо дөрөв дахин өссөн Кот-д'Ивуар тэгш хүртээмжийг зорилт болгож авч үздэггүй.

Өрхүүд асар их ачаалал, хэцүү сонголттой тулгардаг. ДНБ-д эзлэх хувиар өндөр орлоготой орнуудад өрхийн боловсролын зардал 0.3%, бага, дунд орлоготой орнуудад 1%-ийг эзэлж байна. Энэ нь Эль-Сальвадорт ДНБ-ий 1.2%, Марокко д 1.5%, Энэтхэгт 1.8%, Гана улсад 2.5%-ийг тус тус эзэлж байна. Аргентин, Коста Рика, Филиппин, Замби зэрэг орнуудад ядуу өрхийн 20% нь боловсролд бараг юу ч зарцуулдаггүй бол чинээлэг өрхийн 20% нь ДНБ-ий 0.5-1.7%-ийг зарцуулдаг.

Улсаас үзүүлж буй боловсролын үйлчилгээ тэр бүр үнэ төлбөргүй байдаггүй. Бага, дунд орлоготой орнуудын өрхийн зардлын гуравны нэг орчим хувийг улсын сургууль д суралцдаг хүүхэдтэй өрх бүрдүүлдэг. Гватемал, Пакистанд хувийн сургууль д сурдаг хүүхэдтэй өрхүүд зардлын 80 орчим хувийг эзэлдэг бол Хятад, Кени улсад зардлын 60 орчим хувийг улсын сургууль д сурдаг хүүхэдтэй өрхүүд бүрдүүлдэг. Бүгд Найрамдах Танзани улсын хөдөө орон нутгийн өрхүүдийн дөрөвний гурваас илүү хувь нь бага сургууль д хувь нэмэр заавал өгөх ёстой гэж үздэг бөгөөд хэрэв төлбөрийн төлөлт хоцорвол хүүхдүүд шийтгэдэж болзошгүйг тэмдэглэжээ. Австрали улсад эцэг эхийн өгдөг хандив сургууль хоорондын тэгш бус байдлыг улам хурцатгадаг.

Хувийн сургалтын нэмэлт төлбөр олон өрхийн хувьд томоохон зардал болдог. Хятад улсын өрхүүд 2017 онд боловсролын нийт зардлынхаа гуравны нэг орчмыг сургуулиас гадуурх зардалд хуваарилсан бөгөөд энэ нь хөдөөгийн өрхүүдийн 17 хувь байхад хотын өрхүүдийн 42 хувийг эзэлж байна. Египет улсад нэг хүнд ногдох дундаж зардлын эзлэх хувиар бүрэн дунд боловсролын сурагчдын дунд хамгийн чинээлэг өрхийн хүүхдүүд хувийн хичээл сургалтад 51 хувь, хамгийн ядуу нь 29 хувийг зарцуулдаг байна. Мьянмар улсад хувийн нэмэлт сургалт нь өрхийн боловсролын нийт зардлын 42 хувийг эзэлж байна.

Хувийн үйлчилгээ үзүүлэгчид өрхийн шууд төлбөрт найддаг. Дундаас дээш болон өндөр орлоготой 51 боловсролын тогтолцооны 28 нь хувийн дунд сургуулиуд орлогынхоо 80-аас доошгүй хувийг төлбөрөөр бүрдүүлдэг. Бага болон бага дунд орлоготой орнуудад санхүүгийн бололцоогүй эцэг эхчүүд хувийн сургуулийн зардлыг төлөхийн тулд янз бүрийн стратеги ашигладаг. Дэлхий даяар зургаан гэр бүл тутмын нэг нь сургуулийн төлбөрийг төлөхийн тулд хуримтлал үүсгэдэг бол нийт өрхийн 8 орчим хувь нь зээл авдаг. Гаити, Кени, Филиппин, Уганда улсуудад нийт өрхийн 30 буюу түүнээс дээш хувь нь сургуулийн төлбөрийн зээл авдаг байна.

КОВИД-19 цар тахал хувийн сургуулийн санхүүжилтэд ихээхэн нөлөөлсөн. Цар тахал нь хувийн сургуулиуд, тэр дундаа сургалтын төлбөрөөс ихээхэн хамаардаг сургуулиудад нөлөөлсөн. Нигери улс хувийн сургуулийн багш нарын цалинг олгохын тулд бага хүүтэй зээлээр урамшуулах багц хөтөлбөрийг эхлүүлсэн. Гана улсын хувийн сургуулиудад жижиг дунд үйлдвэрүүдэд зориулсан ерөнхий хөтөлбөрийн хүрээнд дэмжлэг олгосон. Вьетнам улс хувийн сургуулийн багш нарын цалинг олгохын тулд бэлэн мөнгө шилжүүлэх хөтөлбөрийг өргөжүүлсэн. Панамд эцэг эхчүүдийн 35-40 хувь нь сар бүрийн төлбөрөө төлж чадахаа больсон. Эквадорт улсын сургуулийн элсэлт 6.5 хувиар нэмэгдсэн буюу хувийн сургуулиас 120,000 сурагч шилжин ирсэн байна.

Хувийн хэвшлийн боловсролын санхүүжилтэд үзүүлэх тусламжийн ашиглалт маргаан дагуулж байна. 1.2 тэрбум орчим долларын боловсролын багцын 15 хувийг Олон улсын санхүүгийн корпораци хувийн сургуулиудын сүлжээнд хуваарилсан боловч иргэний нийгмийн байгууллагуудын шахалтаар 2019 онд төлбөртэй хувийн сургуулиудад хөрөнгө оруулахаа зогсоосон. Боловсролын төлөөх дэлхийн түншлэл нь хувийн хэвшлийн стратеги боловсруулсан боловч хэлэлцээний явцад ашгийн төлөө боловсролын үндсэн үйлчилгээ явуулдаг байгууллагуудад дэмжлэг үзүүлэх чиглэлд санхүүжилт ашиглахыг хориглосон заалтыг гаргасан.

Хандивлагчид төр, хувийн хэвшлийн түншлэлийг туршиж байна. Мөнгөний хомсдолтой засгийн газрууд Египет, Филиппин, Өмнөд Африкт улсын сургуулийн дэд бүтцийг сайжруулах, өргөжүүлэхийн тулд хувийн хөрөнгө босгосон. Зарим хандивлагчид өөрсдийн хөрөнгөө ийм төрлийн түншлэлээр дамжуулан санхүүжилт босгох хурдасгуур болгон ашиглахыг эрэлхийлдэг. Гэхдээ түншлэлийг бий болгож, хэрэгжүүлж, зохицуулж чаддаг засгийн газрууд зорилгодоо хүрэхийн тулд төрийн худалдан авалтыг илүү сайн ашиглаж чадна гэсэн эргэлзээ байна.

Боловсролын салбарт хандивын болон корпорацийн үйл ажиллагааны санхүүгийн дэмжлэг бага байна. Хэдийгээр хүмүүнлэгийн сангуудаас боловсролд зарцуулж буй хөрөнгийн хэмжээ нэмэгдэж байгаа гэсэн ойлголт байгаа ч энэ нь харьцангуй бага хэвээр байна. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын санаачилга болох Хөгжлийн төлөөх сангуудын сүлжээний 143 сангаас олгосон хандивын талаар системчилсэн дүн шинжилгээ хийхэд 2013-2015 оны гурван жилийн хугацаанд боловсрол салбарт 2.1 тэрбум ам. долларыг олгосон байв. Энэ нь нийт хандивын 9 хувьтай тэнцэж байв.

нөлөөлөл

Боловсролын салбар дахь төрийн бус оролцогч талуудын гүйцэтгэх үүргийн талаарх маргааны гол цөм нь үр ашиг, инноваци, тэгш боломжийн тухай байна.
Дэлхийн тэс өөр хоёр үзэл бодол зөрчилддөг тул мэтгэлцээн нь ихэвчлэн хурцадмал байдал,үл итгэлцэлээр тодорхойлогддог. Төрөл бүрийн оролцогч бүлгүүд олон нийтийн санаа бодол, боловсролын бодлогод төрийн бус оролцогч талуудад илүү хүчтэй үүрэг гүйцэтгэхийн төлөө эсвэл түүний эсрэгээр нөлөөлөхийг оролддог. Тэдний хэрэгсэл нь ухуулга, сурталчилгаа, лобби хийх сүлжээ, судалгаа, санхүүжилт бөгөөд энэ нь ихэвчлэн бараа,үйлчилгээний борлуулалттай холбоотой байдаг. Оролцогч талууд өөрсдийн үзэл бодлыг давамгай болгохын тулд хууль ёсны ба хууль бус арга хэрэгслийг ашигладаг энэхүү улс төрийн үзэл санаа, эдийн засгийн ашиг сонирхлын өрсөлдөөний үед тулгамдаж буй асуудал бол төрийн боловсролын бодлогын үйл явцын ил тод, шударга байдлыг хадгалах, хувийн ашиг сонирхлоос хол байлгах явдал юм.

Ихэнх оролцогч бүлгүүд боловсролын салбар дахь төрийн бус оролцогчдын талаар нэгдмэл байр суурь баримталдаггүй.
Иргэний нийгмийн байгууллагууд боловсролын салбар дахь хувьчлал, бараа бүтээгдэхүүнд шүүмжлэлтэй хандаж, боловсролыг ардчилсан хяналтад байлгах ёстой гэж үздэг. Гэвч Боловсролын төлөөх дэлхийн кампанит ажил гэх мэт эрхэд суурилсан хөдөлгөөний хүрээнд ч гишүүд улс орных нь бодит байдал нөлөөлсөн илүү нарийн үзэл бодлыг баримталдаг. Энэхүү тайланд зориулан гаргасан гишүүдийн дунд явуулсан санал асуулгад 43 хувь нь ашгийн төлөөх хангамжийн талаар сөрөг байр суурьтай, 12 хувь нь дэмжсэн байсан бол төр,хувийн хэвшлийн түншлэлийн хувьд 41 ба 20 хувийн харьцаатай байсан бөгөөд үлдсэн хэсэг нь холимог байр суурьтай байна.

Дэлхийн нөлөөллийн сүлжээнүүд хувьчлал, арилжааны үйл ажиллагаа нь суралцах эрхэд заналхийлж буй аюул гэж үздэг.
Энэхүү хэтийн төлөвийг бүх нийтийн боловсрол олгох, боловсрол дахь хувийн оролцоог зохицуулах талаар улс орнуудын хүний эрхийн үүргийн талаарх Абижаны зарчмуудад тусгасан байдаг. 2018 онд Кени улсын 10 иргэн Олон улсын санхүүгийн корпораци (ОУСК)-ийн хариуцлагын бие даасан механизм болох Нийцлийн зөвлөх Омбудсманд хандаж ашгийн төлөө ажилладаг Бридж олон улсын академи нь сургалтын хөтөлбөр, эрүүл мэнд, аюулгүй байдал, хөдөлмөрийн стандартыг зөрчиж байна гэж гомдол гаргажээ. 2020 онд ОУСК сургуулийн сүлжээн дэх хөрөнгө оруулалтыг царцаасан бол Дэлхийн банкны бие даасан үнэлгээний баг хувийн сургуулиудын хөрөнгө оруулалтын үнэлгээг эхлүүлсэн.

Олон улсын байгууллагуудаас төрийн бус үйлчилгээ үзүүлэгчдэд үзүүлэх шүүмжлэлгүй дэмжлэг, нөөц нь хөтөлбөрт нөлөөлдөг.
Дэлхийн банкнаас бодлого боловсруулахад нөлөөлөх арга замуудын дунд Боловсролын үр дүнг сайжруулах тогтолцооны аргын хүрээнд суралцахыг дэмжих бодлогын 13 чухал чиглэлийн нэг гэж тооцогддог хувийн хэвшлийн оролцооны модуль байдаг. Энэ нь 10 орны 9-д нь хувийн хэвшлийн оролцоог өргөжүүлэхийг зөвлөсөн байна. НҮБ-ын Хүүхдийн сангаас зохион байгуулдаг Боловсролын үр нөлөөний сан нь боловсролын салбарт сайн туршлагагүй байсан ч үр дүнд суурилсан санхүүжилтийн төслүүдэд нөлөөллийн хөрөнгө оруулагчдыг татдаг. Олон улсын дэмжлэгийн үр шимийг хүртэж буй байгууллагуудын дунд Англид улсын сургуулиудыг ажиллуулж, Либери, Өмнөд Африк зэрэг улс орнуудад төр, хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлэх талаар зөвлөгөө өгөх, туслах хүртэл өргөжин тэлсэн Арк багтдаг.

Боловсролын салбарын төрийн бус оролцогч талууд ямар үүрэг гүйцэтгэх ёстой талаар сангуудын байр суурь харилцан адилгүй байдаг.
Корпорацийн болон хандивын сангуудын харилцан адилгүй урам зориг нь тэднийг бүлэг болгон ангилахад хэцүү болгодог. Сангуудыг голдуу тодорхой чиглэлд бодлогод нөлөөлөхийг оролддог гэж шүүмжилдэг. Леманн хандивын сан нь олон удаагийн зөвлөлдөөний дараагаар Бразил улсад үндэсний сургалтын стандартыг нэвтрүүлэхэд тусалсан.

Багш нарын нэгдлүүд нь бүх нийтийн боловсролыг дэмжих нөлөөллийн ажлын тэргүүнд байдаг.
Баталгаагүй арилжаа,төрийн үйлчилгээг аутсорсинг хийх замаар нийтийн боловсролыг сулруулах оролдлогыг нэгдлүүд үр дүнтэй илчилсэн. Багш нарын нэгдэл болох Боловсрол Интернэшнл нь Латин Америкт, тухайлбал, Коста Рика, Доминикан улсад төр, хувийн хэвшлийн түншлэлийг өргөнөөр ашиглах нь ижил зорилготой төрийн байгууллагуудад хор хөнөөл учруулах эсэх талаар эргэлзэж асуудал дэвшүүлж байна. Гэвч зарим тохиолдолд нэгдлүүдийн тактик нь нийтийн боловсролыг бэхжүүлэх хүчин чармайлтыг сулруулж байна гэж шүүмжилдэг.

Бизнесүүд боловсролын шинэчлэлийн талаарх ухуулга сурталчилгаагаа хүний капиталын нэр томьёогоор илэрхийлдэг.
Японы Бизнесийн холбоо нь дэлхий даяарх эдийн засгийн хүчирхэг лобби шиг орчин үеийн шинэчлэл,21-р зууны ур чадварт уриалсан боловсролын бодлогын зөвлөмжийг гаргасан. Зарим хүмүүс энэхүү зөвлөмжийг ажил олгогчдын ажилд авах, сургах арга барилтай зөрчилдөж байна гэж шүүмжилсэн. Боловсролын төлөөх дэлхийн бизнесийн нэгдэл нь гишүүдийнхээ туршлага, манлайлал, нөөцөд тулгуурлан боловсролд улс төрийн ач холбогдол өгөхийг уриалж байна. Татвараас зайлсхийхийн эсрэг кампанит ажилд чин сэтгэлээсээ оролцох нь нийтийн боловсролд үзүүлэх хамгийн сайн дэмжлэг болно гэж шүүмжлэгчид эсэргүүцэж байна. Засгийн газрын бүтээгдэхүүнийг олон нийтийн сайн сайханд нийцэхгүй байдлаар борлуулдаг маркетингийн арга техникийг ашигладаг боловсролын технологийн пүүсүүд КОВИД-19 хямрал,зайн сургалтад шилжих үед хэрхэн хүчин чармайлтаа эрчимжүүлсэн нь ч мөн олны анхааралд орсон асуудал болж байна.

БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН АСАРГАА БА БОЛОВСРОЛ

3-аас доош насны хүүхдийг асрах, боловсрол олгох үйлчилгээг төрийн бус оролцогч талууд удирдан чиглүүлдэг.
2018 онд өндөр орлоготой 33 орны нийт элсэгчдийн 57 хувь нь хувийн байгууллагуудад хамрагдсан байна. Австрали, Ирланд, Нидерланд, Шинэ Зеланд, Их Британи улсуудад ашгийн төлөөх хувийн хэвшил тэдгээр үйлчилгээг голчлон хариуцаж байна. 2017 онд ХБНГУ-д элсэгчдийн 73 хувь нь хувийн хэвшлийн байгууллагуудад хамрагдсан байсан бол эдгээрийн зөвхөн 3 хувь нь ашгийн төлөө байгууллага байсан байна. Дундаж орлоготой 33 оронд төрийн бус оролцогч талууд 3 хүртэлх насны хүүхдүүдийн элсэлтийн 46 хувийг эзэлж байсан бөгөөд хамрах хүрээ нь ОХУ-д бараг 0 хувиас Турк улсад 100 хувь хооронд байна. Сальвадор зэрэг цөөн хэдэн улс л төрийн хангамжийг ихээхэн нэмэгдүүлэх чиглэлд шилжсэн. Колумб, Гватемал, Перу зэрэг Латин Америкийн орнууд олон нийтэд түшиглэсэн хүүхдийн асаргааны жижиг хэмжээний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн. Чинээлэг орнуудад харьцангуй түгээмэл байдаг ажил олгогчид суурилсан хангамж нь ядуу буурай орнуудад дөнгөж ааажмаар бий болж байна. Гол бэрхшээл бол албан салбарын ажил эрхлэлт нь бага, дунд орлоготой орнуудын ажил эрхлэлтийн дөнгөж 30 хувийг эзэлдэг явдал юм.

Төрийн бус оролцогч талууд ерөнхий боловсролоос илүү сургуулийн өмнөх боловсролын дэд салбарыг илүү чухалчилдаг.
2000-2019 оны хооронд сургуулийн өмнөх боловсролын нийт хамран сургалтад хувийн хэвшлийн байгууллагуудын эзлэх хувь 28.5-аас 37 хувьд, Зүүн болон Зүүн өмнөд Азийн орнуудад 55 хувьд хүрчээ. Хятад улсад "хөдөө аж ахуй, аж үйлдвэрийг нэгэн зэрэг хөгжүүлэх" бодлогын хүрээнд хувийн хэвшлийн байгууллагуудын эзлэх хувь 31 хувиас 57 хувь болж өссөн байна. Вьетнам улсад хувийн хэвшлийн элсэлтийн эзлэх хувь 2003 онд 60 хувь байсан бол 2014 онд 12 хувь болж буурсан. Зүүн Европын орнуудад, тэр дундаа Украинд эзлэх хувь 1%-иас бага, Карибын тэнгисийн орнуудад (жишээ нь Антигуа, Барбуда) болон хангамж нь олон нийтэд суурилсан (жишээ нь Вануату) эсвэл шашны зорилготой холбоотой (жишээ нь Самоа) Номхон далайн орнуудад 95 хувиас дээш байх хандлагатай байна. Алжир, Египет тэргүүтэй Хойд Африк, Баруун Ази нь сургуулийн өмнөх боловсролын элсэлтийн хувийн хэвшлийн байгууллагуудын эзлэх хувь 2000 онд 53% байсан бол 2019 онд 36% болж хамгийн их буурсан бүс нутгуудад тооцогдож байна. Харин 2000-2018 оны хооронд хувийн байгууллагуудын эзлэх хувь Израильд 5-аас 36 хувь, Кувейтэд 26-аас 45 хувь болж өссөн байна.

Төрийн бус хэвшлийн сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний зардал ядуу хүмүүсийн хувьд хэтэрхий өндөр байна.
Өрхийн судалгаанаас харахад Сахарын цөлөөс урагш орших Африкийн долоон орны зургаад нь төрийн бус боловсролын байгууллагын элсэлтийн эзлэх хувийг дунджаар 20 хувиар дутуу үнэлсэн байна. Төрийн бус боловсролын байгууллага нь голчлон ийм үйлчилгээ илүү түгээмэл байдаг хот суурин газрын эрэлт хэрэгцээг хангадаг бөгөөд үүнийг төлж чадах чинээлэг өрхүүдэд үйлчилдэг байна. Өрхийн жилийн хэрэглээнд хувийн сургуулийн өмнөх боловсролын эзлэх хувийн авч үзвэл Гана улсын хамгийн чинээлэг өрхийн хувьд 6 хувь, хамгийн ядуу өрхийн хувьд 17 хувь; Этиоп улсад тус бүр 4 болон 21 хувь байна.

Төрийн бус үйлчилгээнд засаглал ба зохицуулалтын хүндрэл учирдаг.
Төрийн бус оролцогч талуудын олон талт байдал нь засаглалыг төвөгтэй болгодог. Камбож улсад олон нийтийн сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын талаар тусдаа журам, тогтоолууд байдаг. Шри Ланкад олон салбарын зохицуулалтын тогтолцоо байхгүй байгаа нь хэд хэдэн яам (боловсрол, эрүүл мэнд, эмэгтэйчүүд, хүүхдийн асуудал хариуцсан) болон мужийн зөвлөлүүдийн ажлын цар хүрээ давхцаж байна гэсэн үг юм. Нигерийн Лагос хотод төрийн боловсролын яамнаас өндөр төлбөртэй (68%) хувийн сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудад шалгалт хийх магадлал нь бага төлбөртэй (48%) байгууллагуудаас өндөр байна. Кени улсын Найроби хотод олон нийтийн сургуулиудыг шашны, асрамжийн болон ашгийн төлөөх сургуулиудаас илүү олон удаа шалгадаг.

Төрийн бус үйлчилгээ үзүүлэгчдийн чанар олон янз байдаг.
Бага, дунд орлоготой олон оронд хувийн хэвшлийн сурган хүмүүжүүлэгчид төрийн байгууллагынхтай харьцуулахад бэлтгэл муу, мэргэжил дээшлүүлэх боломж хомс байдаг. Хувийн хэвшлийн багш нарт наад захын шаардлага тавигддаггүй тул хувийн цэцэрлэгийн багш нарын ердөө 8 хувь, харин улсын цэцэрлэгийн багш нарын 75 хувь нь Гана улсын боловсролын үйлчилгээний сургалтын хөтөлбөрт хамрагддаг. Бразил улсад сургуулийн өмнөх төрийн бус боловсролын байгууллагуудад сургалтыг англи хэлээр удирдан явуулдаг нь хөгжилд тохирсон сургалтын хөтөлбөр болон чанарын талаарх түгээмэл ойлголт хоорондын зөрчилдөөний жишээ юм.

Бага, дунд орлоготой цөөн орнуудад захиргааны шаардлагаас давсан чанарын баталгаажуулалтын журам байдаг.
Ямайка улсад үйлчилгээ нь төрийн бус оролцогчдын гарт байдаг тул боловсролын яам нь мэргэшсэн байцаагчтай байх шаардлагатай байдаг бөгөөд бусад ажилтнууд нь хүүхэд, багш, эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн гишүүдийн хоорондын харилцаа, холбоог багтаасан үндэсний 12 стандартын дагуу сар бүр газар дээр нь очиж хяналт тавьдаг. Филиппин улс засгийн газраас баталгаажуулсан Филиппиний бага насны хүүхдийн хөгжлийн хяналтын хуудсаар дамжуулан үндэсний стандарт, чадамжийг хянадаг.

Төрийн бус оролцогч талууд Бага насны хүүхдийн асаргаа, боловсролын хөтөлбөрийг шинэчилж, дэмжиж байна.
Түүхэнд, тууштай боловсролын ажилтнууд хүүхэд төвтэй

сургалтын алсын хараагаа хэрэгжүүлэхийн тулд албан боловсролын тогтолцооноос гадуур эсвэл тогтолцооны заараг дээр ажиллаж байжээ. Эрдэмтэн судлаачид бага насны хүүхдийн боловсролын хөтөлбөрүүдийн урт хугацааны үр дүнтэй байдалд анхаарлаа хандуулж, төрийн байгууллагуудыг ийм хөтөлбөрүүдийг өргөжүүлэхийг уриалав. Төрийн бус оролцогч талууд Чили дэх хорих ангиудад эхийн хамт хоригдон ажиллаж буй хүүхдүүд,Филиппин дэх ажилчин ангийн ядуу буурай эцэг эхчүүдтэй, Румын дахь байгууллагуудын хүүхдүүдийг өмгөөлж дэмжин ажилладаг. Бернард ван Лиер сан, Ага Хан сан, Нээлттэй нийгэмлэг сан зэрэг байгууллагууд Бага насны хүүхдийн асрамж,боловсролын хөтөлбөрийн дэмжлэг, нөлөөллийг дайчлан ажилладаг.

ДЭЭД БОЛОВСРОЛ

Бараг бүх улс орнууд дээд боловсролыг төрийн болон төрийн бус талуудын хослолоор дамжуулан олгодог.

Дэлхий даяар дээд боловсролын оюутнуудын 33 орчим хувь нь хувийн байгууллагуудад элсэн суралцдаг бөгөөд Төв болон Өмнөд Ази, Латин Америк, Карибын тэнгисийн орнуудад энэ нь хамгийн өндөр хувьтай байдаг. Төрийн бус байгууллагуудын өсөлт нь олон төрлийн эрэлт хэрэгцээг хангадаг. Шашин эсвэл соёлын чиг баримжаатай байгууллагууд нь түүх, уламжлалтай холбогдож, "өөр" төрлийн боловсролын эрэлт хэрэгцээг хангадаг. Элит институциуд нь ихэвчлэн чинээлэг хүмүүсийн "илүү сайн" боловсролын эрэлт хэрэгцээг хангадаг. Эцэст нь, сүүлийн үед жижиг, шашны бус байгууллагууд сүүлийн үед "илүү их" дээд боловсролын эрэлт хэрэгцээг хангахын тулд ялангуяа улсын төсөв хязгаарлагдмал байгаа нөхцөлд хурдацтай хөгжиж байна.

Төрийн бус оролцогчид тогтолцооны чанарт нөлөөлдөг.

Бага төлбөртэй байгууллагууд нь ихэнхдээ мэргэжлийн боловсролын чиг баримжаатай цөөн хэдэн төрлийн мэргэжлийн сургалтыг санал болгодог. Энэтхэгт хувийн коллежийн 40 орчим хувь нь зөвхөн нэг салбарын мэргэжлийг санал болгодог ба ерөнхийдөө боловсролын салбар байдаг. Төрийн бус боловсролын байгууллагуудын багш нар бүтэн цагаар ажиллах магадлал бага байдаг ба Сенегал улсад 20-иос бага хувийг эзэлдэг бөгөөд тэдгээр нь ихэвчлэн төрийн байгууллагуудад харъяалагддаг, хавсран ажиллаж буй профессорууд байдаг. Малайз улсад хавсран ажил эрхлэгчид нь жижиг, шинэ төрийн бус боловсролын байгууллагуудын ажилтнуудын 80 хувийг эзэлдэг байна. Ашгийн чиг баримжаа нь нэмэлт чанарын бэрхшээлүүдийг бий болгодог ба энэ нь зах зээлийн төвлөрөлт ба сурлагын ахиц дэвшлээс илүү ашиг өгөөжийг чухалчилдагтай холбоотой.

Төрийн бус оролцоо нь тэгш боломжийн асуудал үүсгэдэг.

Дундаас дээш орлоготой орнуудад төрийн бус оролцогч талуудын нийт элсэлтэд эзлэх хувь илүү их байгаа нь ирцийн тэгш бус байдалтай холбоотой байдаг. Уругвай улсад төрийн бус институцэд суралцдаг нийт оюутны 75 гаруй хувь нь хамгийн чинээлэг бүлгийнх байдаг бол төрийн институцэд 40 хүрэхгүй хувь байдаг. Гэсэн хэдий ч төрийн бус байгууллагууд гадуурхагдах эрсдэлтэй бүлгийн хүртээмжийг бий болгоход тусалж чаддаг. Саудын Арабт тэд зөвхөн эмэгтэйчүүдэд зориулсан сургалт явуулах замаар эмэгтэйчүүдийн хүртээмжийг өргөжүүлсэн бол Малайзад төрийн сургалтын байгууллагуудад элсэх боломжгүй Хятад, Энэтхэг үндэстний иргэдийг үндэсний цөөнхийн квотоор дамжуулан хүртээмжтэй хамруулдаг. Гэсэн хэдий ч ийм төрлийн тусгаарлалт нийгмийн эв нэгдэлд эрсдэл учруулж болзошгүй юм.

Зохицуулалтын тогтолцоо төрийн бус оролцогч талуудын талаарх засгийн газрын үзэл бодлыг тусгах хандлагатай байдаг.

Хатуу зохицуулалт нь үл итгэх байдалтай холбоотой байдаг бол төрийн бус оролцогчдын тухай илүү таатай үзэл бодол нь магадлан итгэмжлэл, хяналт-шинжилгээ,тэр байтугай төрийн санхүүжилтийг хөнгөвчлөх боломжтой. Зарим улс оронд ашгийн төлөөх байгууллагуудад хатуу зохицуулал хийдэг. Тухайлбал, Аргентин, Чили улс шиг бүхэлд нь хуулиар хориглох эсвэл Филиппин улсад хөрөнгө оруулалтын өгөөжийн 10 хувийн дээд хязгаар тавих замаар төсвийн хуваарилалтад хязгаарлалт хийдэг. Ерөнхийдөө чанарын баталгаажуулалтын механизм нь улс орнуудад хуурамч бизнесийн үйл ажиллагаа явуулдаг эсвэл чанар муутай үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудыг хаахад тусалсан. 2017 онд Пакистаны Дээд боловсролын комисс тус улсад хууль бус үйл ажиллагаа явуулж буй 153 байгууллагыг илрүүлжээ. Гэвч төрийн бус байгууллагуудыг магадлан итгэмжлэх,хянах нөөц хомс байдаг.

Тэгш боломжийг хөхиүлэн дэмжих зохицуулалт нь захиргааны дүрэм журмаас бага түгээмэл байдаг.

Эмзэг бүлгийн дээд боловсролын хүртээмжийг сайжруулахад чиглэсэн квот эсвэл элсэлтийн тусгай шалгуур нь төрийн бус боловсролын байгууллагуудад огт хамаардаггүй байна. Жишээлбэл Энэтхэг улсад энэ нь ихэвчлэн төрийн санхүүжилт авдаг байгууллагуудад зориулагдсан байдаг. Зарим тохиололд Боливи, Эквадор зэрэг улсад төрийн бус байгууллагуудыг зарим оюутнуудад боломжгүй тусламж, тэтгэлэг олгохыг үүрэг болгодог бол Азербайжан,Кени зэрэг улсуудад оюутны төлбөрт дээд хязгаар тогтоодог байна.

Төрийн бус оролцогч талуудын санхүүжилтийн хэлбэрүүд нь чанар, тэгш боломжид ихээхэн нөлөө үзүүлдэг.

Ихэнх төрийн бус оролцогчид, ялангуяа жижиг, элит бус байгууллагуудын санхүүжилт нь сургалтын төлбөрөөс ихээхэн хамаардаг. Гэхдээ ихэнх улс орны засгийн газрууд төрийн бус боловсролын байгууллагуудыг санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг. Индонези улсад багш нар төрийн албан хаагчийн тэтгэмж авдаг бол Тайланд улсын төрийн бус боловсролын байгууллагуудыг дэмжих тусгай сан байдаг. Төрийн сангийн хүртээмж нь судалгааны санаачлагыг хөхүүлэн дэмжих, эсвэл байгууллагуудыг чанар, тэгш боломжийн стандартад нийцүүлэхэд түлхэц өгөх замаар төрийн бус үйлчилгээний хангамжийг сайжруулахад тусална.

Өрхүүд дээд боловсролын санхүүжилтийн ихээхэн хувийг эзэлдэг нь төрийн болон төрийн бус дэмжлэгийн хэрэгцээг нэмэгдүүлж байна.
Бразил, Чили зэрэг улсууд шиг засгийн газрууд нь төрийн бус байгууллагуудад зорилтот төлбөрийн татаас санал болгох, эсвэл 70 гаруй оронд хэрэгждэг дээд боловсролын бүх оюутнуудад зориулсан оюутны зээлийн хөтөлбөрт тэтгэмж олгох боломжтой. Төрийн бус оролцогч талууд нь компани, сан, ТББ, хандивлагчдын тэтгэлэг, мөн оюутны зээл олгох, орлого хуваах гэрээ байгуулах замаар өрхүүдэд төлбөрөө төлөхөд нь тусалдаг.

Төрийн бус оролцогч талууд байгууллагуудыг төлбөрөөс гадна бусад замаар санхүүжүүлэхэд тусалдаг.
Газрын түрээсийг санал болгох, бүтээгдэхүүн үйлчилгээг арилжаалах, зээл, бондоор дамжуулан хөрөнгө босгох зэрэг зах зээлийн үйл ажиллагаанд оролцох зэрэг нь нийтлэг механизмд тооцогдоно. 2020 оны дунд үе гэхэд дэлхий даяарх их, дээд сургуулиудын гаргасан бонд 11.4 тэрбум ам.долларт хүрч, 2019 оныхоос хоёр дахин их болсон байна. Донор болон хандивлагчид байгууллагууд төлбөрийн бус орлогын чухал эх үүсвэрийг бүрдүүлдэг бөгөөд 2020 онд АНУ-ын дээд боловсролын байгууллагуудын цуглуулсан нийт дүнгийн талаас илүү хувийг эзэлж байна.

Төрийн бус оролцогч талууд дээд боловсролд янз бүрийн сувгаар дамжуулан нөлөөлдөг.
Судалгааны түншлэл, лобби, ажил хэрэгч засаглалын шинэчлэл, дэмжлэг зэрэг зарим механизм нь ил тод байдлыг нэмэгдүүлэх, салбарыг бэхжүүлэхэд тусалдаг. Бусад механизм нь, тухайлбал ашгийн төлөөх байгууллагуудаас авахуулаад улс төрчдөд их хэмжээний хандив өгөх (жишээлбэл, Бразил, АНУ-д) нь бодлого боловсруулахад зүй бус нөлөө үзүүлж, байгууллагын бие даасан байдлыг алдагдуулж болзошгүй.

ТЕХНИК, МЭРГЭЖЛИЙН БОЛОН НАСАНД ХҮРЭГЧДИЙН БОЛОВСРОЛ

Төрийн бус оролцогч талууд техникийн болон мэргэжлийн боловсролын үйлчилгээг өргөжүүлэхэд тусалж байна.
2019 онд дэлхий даяар бүрэн дунд, дээд бус боловсрол эзэмшиж буй оюутнуудын 38.5 хувь нь хувийн хэвшлийн байгууллагуудыг сонгосон байна. ЭЗХАХБ-ын орнуудад богино хугацааны дээд боловсролын тусгай мэргэжлийн хөтөлбөрт суралцагчдын 44 хувь нь хувийн байгууллагуудад элсэн суралцаж байна. Төрийн бус оролцогч талуудтай хамтран ажиллах нь техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалт (ТМБС)-ын тогтолцоог хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд илүү нийцүүлэх, тэдний чадавх, нөөцийг нэмэгдүүлэх зорилготой бөгөөд энэ нь төрийн ТМБС-ын нэгдсэн тогтолцоотой улс орнуудад ч хэрэгжиж байна. Бусад нөхцөлд төрийн бус оролцогч талууд нь уламжлалт худалдан авалт, бие даасан сургалтын санаачилга, ихэвчлэн төрөөс зохицуулагддаг төр, хувийн хэвшлийн түншлэлээр дамжуулан мэргэжлийн боловсролыг дэмжиж байна. Буурай орнуудад төрийн бус оролцогч талууд нь эмзэг бүлгийн хүмүүст ТМБС-д илүү тэгш хамрагдах боломжийг олгодог.

Ажил олгогчид албан ба албан бус дагалдан сургалтуудыг хийдэг.
Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас хийсэн сургуулиас ажил руу шилжих шилжилтийн судалгаагаар 33 орны 15-35 насны оролцогчдын 5 хүн тутмын 1-ээс бага нь боловсрол эзэмших явцдаа дор хаяж нэг удаа дагалдан суралцдаг болохыг тогтоожээ. Бага орлоготой орнуудын оролцоо бага байгаа нь хөдөлмөрийн зах зээл ба сургалтын тогтолцооны албан бус байдалтай холбоотой байж болох юм. Хэрэв зохих ёсоор зохицуулж, хүлээн зөвшөөрөхгүй бол дагалдан сургахтай холбоотой сэдэл устаж болзошгүй. Зуучлагч байгууллагууд нь нэн ялангуяа дагалдан сургах сайн уламжлал, туршлагагүй орнуудад ажил олгогчидтой яриа хэлцлийг хийх, сургалтыг сайжруулж, тохирсон ажилтныг холбож өгөх зэргээр дэмжиж ажиллах боломжтой.

Ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх ажлыг ихэвчлэн хувийн ажил олгогчид хийдэг. Албан ёсны ТМБС нь автоматжуулагдах эрсдэлтэй мэргэжлүүдэд голчлон чиглэгддэг бол дахин мэргэшлүүлэх, ур чадвар дээшлүүлэх нь уламжлалт боловсролоос гадуур явагддаг. Албан бус болон ажил олгогчийн ивээн тэтгэсэн сургалтууд давамгайлж байгаа бөгөөд санал болгож буй зүйл нь пүүсийн хэмжээтэй шууд холбоотой. Дэлхийн банкны Хөдөлмөр эрхлэлт, бүтээмжид чиглэсэн ур чадварын хэмжилтийн хөтөлбөрийн үр дүнгээс харахад ажил олгогчид төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын сургалтын хөтөлбөрөөс илүү ажлын байран дээрх сургалтыг илүүд үздэг байна.

Ур чадвар хөгжүүлэх тогтолцоон дахь оролцоот засаглал бэрхшэлтэй байдаг.
ТМБС-ын тогтолцоо нь голчлон төвлөрсөн шинжтэй байдаг. Дэлхийн 150 гаруй орны үндэсний мэргэшлийн тогтолцоо нь ТМБС-ын засаглалыг илүү оролцоотой, зорилгод нийцүүлэх зорилготой боловч ур чадварын ил тод байдал, хамаарлыг сайжруулах нь төрийн байгууллагуудын тэргүүлэх чиглэл хэвээр байна. Чанарын баталгаажуулалтын механизмыг хэсэгчлэн хэрэгжүүлснээр ТМБС-ын тогтолцооны үр ашигт байдалд саад учруулж байна. Хувийн хэвшил ба боловсролын салбарын хамтын ажиллагаа нь сургалтын хөтөлбөр боловсруулахаас илүү ур чадварыг тодорхойлоход чиглэдэг. Эдийн засгийн өөрчлөлтийг даван туулах ур чадварын тогтолцоо нь нийгэм, эдийн засгийн оролцогч талуудыг татан оролцуулах гурвалсан арга барилд тулгуурласан байдаг. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээний талаарх ойлголтыг сайжруулах зорилгоор салбарын ур чадварын зөвлөлөөр дамжуулан мэдлэгт чиглэсэн төр, хувийн хэвшлийн түншлэлийг байгуулсан.

Ур чадвар хөгжүүлэх тогтолцоо нь төрийн болон төрийн бус санхүүжилтэд тулгуурладаг.
Засгийн газрын шууд хуваарилалтаас гадна ТМБС-ын тогтолцоо нь тусгайлсан сургалтын төлбөр эсвэл пүүсүүдийн оролцоот санхүүжилтээр дамжуулан санхүүжилтийг төрөлжүүлэхийг эрмэлздэг. Төрийн бус оролцогч талууд ч гэсэн өрсөлдөөнт худалдан авалтаар шууд оролцдог боловч ур дүн нь харилцан адилгүй

байдаг. Ажил олгогчдыг шимтгэлээс бүрдсэн буцалтгүй тусламжийн хөтөлбөрөөр дамжуулан сургалт явуулахыг уриалдаг. Гэсэн хэдий ч пүүсүүд сургалтад бага хөрөнгө оруулалт хийдэг. Учир нь сургалтын урамшуулал нь шаардлагатай ур чадварыг хөдөлмөрийн зах зээлээс шууд татах урамшууллаас байнга доогуур байдаг. Засгийн газар хувь хүний сургалтын данс эсвэл эрхийн бичгээр дамжуулан сургалтын шууд болон шууд бус зардлыг хариуцах замаар хувь хүмүүст урамшуулал олгодог.

Насанд хүрэгчдэд зориулсан хөтөлбөрүүдэд төрийн бус болон олон нийтийн байгууллагууд зонхилж байна.

Олон нийтийн сургалтын төвүүд, бичиг үсгийн хөтөлбөрүүд болон бусад зүйлсээр дамжуулан төрийн бус байгууллагууд болон иргэний нийгмийн байгууллагууд албан боловсролоос хасагдсан насанд хүрэгчдийн эмзэг бүлэгт хүрч ажилладаг. Зарим тохиолдолд засгийн газрууд насанд хүрэгчдэд үндэсний бичиг үсгийн боловсрол олгох болон хоёр дахь боломж олгох хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд эдгээр байгууллагуудад найддаг бөгөөд бусад нөхцөлд, ялангуяа Латин Америкт ийм төрлийн бүлгүүд насанд хүрэгчдийн бичиг үсгийн боловсролд зонхилох бус хэлийг сурталчлах замаар тус улсын насанд хүрэгчдийн боловсрол олгох тогтолцоог эсэргүүцэх; бусад нөхцөлд хандивлагчдын тэргүүлэх чиглэлүүд тэдэнд нөлөөлдөг. Засгийн газрын бодлого боловсруулахад тэдний оролцоо хязгаарлагдмал хэвээр ч Баруун болон Төв Африкт төвлөрлийг сааруулах, гаднаас нөөц татах (аутсорсинг) стратеги нь эерэг үр дүнд хүргэж байгаа бөгөөд төрөөс нөөцөд хяналт тавьж, хуваарилж, харин төрийн бус оролцогч талууд үйлчилгээний хангамжийг хариуцдаг.

Хувийн хэвшлийн салбар насанд хүрэгчдийн боловсролд, ялангуяа хэлний сургалтанд үүрэг оролцоогоо өргөжүүлж байна.

Хувийн компаниуд нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэх санаачилга эсвэл мэдээлэл, харилцаа холбооны технологийн хангамжийн хүрээнд олон нийтийг хөгжүүлэх замаар насанд хүрэгчдийн боловсрол олгох ажилд оролцдог. Хэлний сургалт ба үнэлгээний ач холбогдол улам бүр нэмэгдэж байгаа нь ашгийн төлөөх пүүсүүдийг татах болсон. Аргентин, Перу улсын англи хэл суралцагчдын 40 орчим хувь нь хувийн хэлний байгууллагуудад суралцдаг. Хөдөлгөөнт хэрэглүүртэй хэл сурах нь мөн дэлгэрч байгаа ч үр дүнтэй эсэх нь маргаантай байна.

ЗӨВЛӨМЖ



Төрийн болон хувийн хэвшлийн гэсэн энгийн хоёр хэлбэрээс гадна төрийн бус сургуулийн олон төрөл байдаг. Түүгээр ч зогсохгүй төрийн бус оролцогч талуудын үүрэг нь сургалтаас гадна бусад олон оролцооны үйл ажиллагааг боловсролын янз бүрийн түвшинд нөлөөллийн олон талт сувгуудаар дамжуулан хүргэх хүртэл өргөжиж байна. Бодлого боловсруулагчдын өмнө тулгамдаж буй асуудал бол боловсролын салбар дахь төрийн бус талуудын оролцоо нь хүлээн зөвшөөрөгдсөн чанарын стандартад нийцэж байгаа эсэхээс гадна төрийн бус оролцогч талууд боловсрол эзэмших тэгш боломж, хүртээмжийг хангах хүчин чармайлтад хэрхэн тусалж, эсвэл саад болж байгаад оршиж байна.

Боловсрол эзэмших эрхийг хангах, хэрэгжүүлэх засгийн газрын үүрэг даалгавартай холбоотойгоор санхүүжилт, хангамжийн тухай хоёр стратегийн чиглэл онцгойлон гарч ирж байна. Нэгдүгээрт, 2015 онд засгийн газрууд бүх хүүхэд, залуучуудад үнэ төлбөргүй, улсын төсвөөс санхүүждэг нэг жилийн хугацаат сургуулийн өмнөх боловсрол, 12 жилийн хугацаат бага, дунд боловсролын хүртээмжийг хангах амлалтыг өгсөн. Гэсэн хэдий ч гурван орны нэг нь ДНБ-ий дөрөв хүрэхгүй хувийг, төсвийн нийт зардлын 15 хувийг боловсролын салбарт зориулдаг тул олон улс энэхүү амлалтаа шаардлагатай санхүүжилтээр хангаж чадахгүй байна. Хоёрдугаарт, засгийн газрууд боловсролыг түгээх, удирдахад хэр хүчтэй үүрэг гүйцэтгэхээ шийдэх хэрэгтэй. Сургуулийн сонголт болон төрийн бус оролцогч талуудын талаарх тэдний хэтийн төлөв харилцан адилгүй байна.

Төрөл бүрийн төрийн бус оролцогч талууд боловсролын олон салбарт илүү тодоор гарч ирж байна. Бизнесүүд боловсрол олгох ажлыг ашгийн үйл ажиллагаа болгох эсэх, бараа, үйлчилгээгээ хэрхэн зах зээлд гаргах талаар, мөн тэд хэний өмнө (зөвхөн хувьцаа эзэмшигчид үү эсвэл бусад хүмүүс үү?) хариуцлага хүлээх ёстой вэ гэдгээ сонгодог. ТББ, иргэний нийгмийн байгууллагууд тэргүүлэх чиглэлээ сонгож, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэхээ шийддэг: зөрүүг өөрсдөө нөхөх үү, эсвэл төрөөр хийлгэхээр нөлөөллийн ажил хийх үү? Сангууд ч мөн тэргүүлэх чиглэлээ тодорхойлж, нийгэмд хэрхэн нөлөөлөх, боловсролын тогтолцоотой хэр ойр ажиллахаа сонгодог. Багш нар болон тэдний төлөөллийн байгууллагууд, нийтийн боловсролын тогтолцоонд итгэх итгэлийг бэхжүүлэх эсвэл үгүй хийх сонголт хийдэг.

"Хэн сонгож, хэн алдах вэ?" хэмээх энэхүү тайлангийн уриалга бол бодлого боловсруулагчид дараах үндсэн сонголтуудын хүрээн дэх төрийн бус оролцогч талуудтай хамтран ажиллаж буй харилцаагаа дахин эргэн бодох урилга юм. Үүнд: сонгох эрх чөлөө ба тэгш боломжийн хоорондох; санаачилгыг дэмжих (жишээ нь тогтолцооны аль ч хэсэгт чанарыг сайжруулах) болон стандарт тогтоох (жишээ нь бүх суралцагчдын чанарыг сайжруулах); янз бүрийн арга барил, хэрэгцээтэй хүн амын бүлгүүд; тэдгээрийн ойрын амлалтууд (жишээлбэл, ТХЗ 4-ийн дагуу 12 жилийн үнэ төлбөргүй боловсрол) болон аажмаар хэрэгжүүлэх (жишээлбэл, бүрэн дунд боловсролын дараах шатны боловсрол); боловсролын болон нийгмийн бусад салбаруудын хоорондох сонголтууд зэрэг багтана.

Эдгээрийг бодолцож, санхүүжилт, чанар, засаглал, инноваци, бодлого боловсруулахад боловсрол дахь тэгш боломжийг хангахын тулд #RightttheRules дүрмийг хэрэгжүүлэхэд туслах зорилгоор дараах зөвлөмжүүдийг боловсруулав. Гол зорилго нь тэгш байдлыг алдагдуулахгүйгээр чанартай боловсрол олгоход төрийн бус байгууллагуудын оруулж чадах хувь нэмрийг ашиглах явдал юм. Энэхүү нөөц бололцоог дайчлах нь төрийн үйлчилгээний чанар муу, тэгш бус байдлыг зориудаар шийдвэрлэхэд засгийн газруудыг уриалж болох юм. Тус зөвлөмжүүд нь засгийн газруудад голчлон чиглэсэн ба тэгш боломж ба бүгдийг хамрах байдлын үүднээс дараах таван үндсэн асуултад тодорхой хариулт авах зорилготой. Түүнчлэн, тэдгээрийг ТХЗ 4-т хүрэх ахиц дэвшлийг дэмжих зорилго бүхий боловсролын бүх оролцогч талуудад нөлөөллийн хэрэгсэл болгон ашиглах зорилготой юм. Иймээс энэхүү зөвлөмж нь төрийн болон төрийн бус бүх оролцогч талуудыг #ЯгЗөвДүрмээр тоглохыг уриалж байна.

1. БОЛОВСРОЛЫН САНХҮҮЖИЛТ ЗАРИМ СУРАЛЦАГЧДАД БОЛОМЖ ОЛГОЖ, ЗАРИМЫГ НЬ ХАСЧ БАЙГАА ЮУ?

1 жилийн сургуулийн өмнөх боловсрол, 12 жилийн бага,дунд боловсролыг үнэ төлбөргүй болгох амлалтаа биелүүлэх. Гэхдээ тэгш боломжийг хангаж чадвал төрөөс санхүүжүүлнэ гэдэг нь нийтэд олгогдоно гэсэн үг биш юм.



Засгийн газар чанартай боловсролыг хүртээмжтэй хэлбэрээр үнэ төлбөргүй олгох ёстой. Улс орон нь үнэ төлбөргүй олгохоор амлалт өгсөн боловсролын бараа, үйлчилгээнд айл өрхүүд төлбөр төлөхгүй байх боломжоор хангах шаардлагатай.

Засгийн газар өрхийн орлого, зарлагын судалгааг ашиглан шууд төлөх боловсролын зардлыг хянах шаардлагатай. Тэд бараг баримтжаагүй зардлыг үл тоосноор тэгш бус байдлыг нэмэгдүүлдэг.

Улсын болон төрийн бус боловсролын үйлчилгээ үзүүлэгчид сурагчдад ижил нөхцлийг санал болгох ёстой. Боловсролыг улсаас санхүүжүүлэх амлалт нь бүх боловсролыг олон нийтэд олгох ёстой гэсэн үг биш юм. Гэхдээ бүх боловсролын байгууллагыг нэгдсэн дүрэм журам, санхүүгийн дэмжлэг, хяналтын механизмтай нэг тогтолцооны нэгэн хэсэг гэж үзэх ёстой.

Санхүүжилтийг төрөлжүүлэх аливаа оролдлогыг тэгш боломжийг хангахуйц байдлаар төлөвлөх ёстой. Улсын сургуулийн удирдлагыг гэрээгээр ажиллуулах, хувийн сургуулиудын үйл ажиллагааны зардалд тэтгэмж олгох, эсвэл өрхүүдэд сонгосон сургуульд нь сургах санхүүгийн дэмжлэг олгох нь суралцагчдад ашиг тусаа амархан өгөх болно.


Сургуулиуд сурагчдыг сонгох учиргүй. Улс орнууд боловсролын салбарт ялгаварлан гадуурхалгүй байхыг тууштай баримталдаг бөгөөд энэ зарчмыг сургуульд элсэх бодлогод тусгах ёстой. Түүнчлэн,гэр бүл,сурагчдын сургууль сонгох эрх нь тэгш бус байдлыг даамжруулж болохгүй.

Төрөөс санхүүждэг төрийн бус үйлчилгээ үзүүлэгчид төлбөр авах ёсгүй. Бүх улс орнууд сургуулийн өмнөх, бага,дунд боловсролыг үнэ төлбөргүй байлгахыг зорьж байх ёстой ч олонх нь бодит байдал дээр энэ зорилгоос хол байна. Төрөөс хамааралтай хувийн байгууллагууд хүртэл төлбөр авч байна.

Ашиг олох нь сургуулийн өмнөх,бага,дунд боловсролыг үнэ төлбөргүй олгох амлалттай нийцэхгүй байна. Ашиг олохыг зохицуулах эсвэл хориглох нь тэгш бус байдлыг улам хурцатгаж бүй сургууль сонголтын бодлогыг шийдвэрлэхэд ашиглагдаж болно.

2. БҮХ СУРАЛЦАГЧИД ХҮРТЭХ ЁСТОЙ ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭГ АВЧ ЧАДДАГ УУ ЭСВЭЛ ЭНЭ АМЛАЛТ БОГИНО ХУГАЦААНД ӨӨРЧЛӨГДДӨГ ҮҮ?

Төрийн болон төрийн бус боловсролын бүх байгууллагад мөрдөгддөг чанарын стандартыг бий болгох



Засгийн газар боловсролын бүх байгууллага мөрдөх чанарын стандартыг боловсруулах хэрэгтэй. Чанарын стандарт нь боловсролын үйлчилгээний орц, гарц, үр дүнг хамарсан байх төдийгүй боломжийг ихээр алдах магадлалтай хүмүүсийг хамгаалдаг байх учиртай. Мөн аюулгүй байдал,оролцоог хамруулах учиртай. Түүнчлэн сургуулийн нөхцөл байдлыг тодорхойлж,улмаар цаашид сайжруулахад тэд туслах ёстой. Тэдний амжилтыг улсын болон хувийн сургууль бүрээр үнэлж, олон нийтэд мэдээлж байх учиртай.

Багш нарыг мэргэжлийн хүн гэж бүх сургуульд үнэлэгдэх

ёстой. Багшийн ур чадвар, мэргэжил дээшлүүлэх боломж нь үйлчилгээ үзүүлэгчээс хамаарч өөр өөр байх учиргүй. Багшийн хөдөлмөрийн зах зээлийн хэсэгчлэл,цалин хөлс,орчин нөхцлийн ихээхэн хэмжээний тэгш бус байдал зэрэг нь боловсролын тогтолцоо буруу ажиллаж байгаагийн хүчтэй илрэл юм. Эдгээр тэнцвэргүй байдлын үндсэн шалтгааныг засгийн газрууд аажмаар арилгах хэрэгтэй.


Стандартуудыг хянаж, мөрдүүлэх зорилгоор чанарын баталгааны механизмыг бий болгох шаардлагатай. Сургуулийн хяналт шалгалт, үнэлгээ, сургалтын үнэлгээний төрийн хяналт нь үйлчилгээ үзүүлэгчээс үл хамааран нийтлэг байх ёстой. Эдгээр механизмд төрийн хэрэгжилтийн чадавхыг харгалзан үзэх ёстой.

Улс орнууд техник,мэргэжлийн болон дээд боловсролын чанарын баталгаажуулалтын үйл явцыг илүү сайжруулах шаардлагатай байна. Засгийн газар сургалтыг дэмжих зорилгоор хувь хүмүүст тэтгэмж олгох эсвэл компаниудтай гэрээ байгуулдаг ба залилан мэхлэлтэд өртөх магадлал бүхий эмзэг бүлгийн хүмүүсийг хамгаалах шаардлагатай. Ашгийн төлөөх их, дээд сургуулиуд чанарын доод түвшний боловсрол санал болгож,буруу үйл ажиллагаанд татан оруулж байна.

Засгийн газрууд хувийн нэмэлт сургалтуудыг тогтолцооны чанар,тэгш боломжид сөргөөр нөлөөлөхөөс урьдчилан сэргийлэх хэрэгтэй. Хяналтыг сайжруулах үүднээс багшийн заах зөвшөөрлийн шаардлагаас эхлээд онлайн бүртгэл хүртэл бодлогын хариу үйлдэл өөр өөр байдаг. Хориг тавих нь сонголт байж болох ч албан бус зах зээлд хүргэж болзошгүй. Багш нарын цалин бага, төгсөлтийн шалгалтын өндөр босго зэрэг үндсэн шалтгааныг арилгахад нэн тэргүүнд анхаарах ёстой.

3. ЗОХИЦУУЛАЛТ УР ДҮНТЭЙ, ХЭРЭГЖИХ БОЛОМЖТОЙ ЭСЭХ ЭСВЭЛ БОЛОМЖ ТААРУУ СУРАЛЦАГЧДАД ХОР ХӨНӨӨЛ УЧРУУЛАХУЙЦ ХҮСЭЭГҮЙ УР ДАГАВАР ДАГУУЛАХ УУ?

Төр, төрийн бус боловсролын бүх байгууллагад хамаарах нийтлэг хяналт-шинжилгээ, дэмжлэгийн үйл явцыг бий болгох



Засгийн газрууд төрийн бус оролцогч талуудыг татан оролцуулж, зохицуулалтаар дамжуулан алсын хараагаа хэрхэн хүргэхийг хүсч буй талаар тодорхой алсын хараа, хамрах хүрээтэй байх. Зохицуулалт нь захиргааны болон бодит бус орцын стандартад бус, харин боловсролын үйл явц, гарах үр дүнд анхаарлаа төвлөрүүлж, улсын болон хувийн сургуулиудын хамтын ажиллагаа, олон нийтийн оролцоонд түшиглэн үе шаттайгаар сайжруулах.

Боловсролын үйлчилгээ үзүүлэгчдийг боловсролын аж ахуйн нэгжийн хэмээн зөвшөөрч зохицуулалтыг явуулах бө арилжааны байгууллага гэсэн үүднээс зохицуулж болохгүй. Боловсролын зарим үйлчилгээ үзүүлэгчдийг, тухайлбал, бага насны хүүхдийн асаргаа, боловсрол, хувийн нэмэлт сургалт, мэргэжлийн сургалтуудыг бизнесийн үйл ажиллагаагаар зохицуулагддаг. Үүний нэгэн адил бусад үйлчилгээ үзүүлэгчдийг нийгмийн хамгааллын яам эсвэл шашны байгууллагууд хянадаг.

Зохицуулалт энгийн, ил тод, ур дүнтэй байх ёстой. Зохицуулалтын чадавх шаардлагатай газраа хамгийн бага, авлига хээл хахуульд өртөх магадлал өндөр байдаг нь логик зөрчилдөөн юм. Практик бус дүрэм журмыг хянах, хэрэгжүүлэх чадавх дутмаг тохиолдолд зохицуулалт нь үр ашиггүй болдог.

Засгийн газар зохицуулахыг хүсч буй үзэгдлийн шалтгааны талаар шударга байх хэрэгтэй. Хяналт-шинжилгээ, дэмжлэг үзүүлэх үйл явц нь нийтлэг байх ёстой бөгөөд энэ нь засгийн газар хүүхдүүдийн сурдаг сургуулийн төрлөөс үл хамааран бүх хүүхдийн боловсролд санаа тавьдаг гэдгийг харуулах ёстой. Засгийн газрууд мөн төрийн бус үйлчилгээ үзүүлэгчидтэй итгэлцлийн харилцааг бий болгож, сургуулиа ур дүнтэй удирдахад нь зөв хөшүүргийг хүргэх хэрэгтэй.

4. БОЛОВСРОЛЫН ТАЛААРХ ШИНЭ САНААНУУД ТЭЖЭЭГДДЭГ ЭСВЭЛ БООМЛИГДДОГ УУ?

Бүх нийтийн сайн сайхны төлөө боловсролын тогтолцоогоор дамжуулан инновацийг түгээх



Бодлого боловсруулагчид инновацийг тодорхойлох, шинэлэг санааг хөгжүүлэх цаг хугацаа, орон зайг тодорхойлох чадвартай байх. Шинэ санааг дангаар эзэмших эрх хэнд ч байхгүй. Боловсрол нийгмийн хүчин чармайлт,цогц тогтолцоо юм. Бодлого боловсруулагчдын

өмнө тулгамдаж буй асуудал туршилт хийхээс илүүтэй нийцүүлэх замаар инновацийг дэмжих явдал юм.

Засгийн газар зөвшилцөөний хандлагыг эрхэмлэсэн, бүх нийтэд үйлчилдэг боловсролын тогтолцоог бүрдүүлэхийн төлөө бүх оролцогчидтой хамтран ажиллах ёстой. Инновацийг дэмжихийн тулд итгэлцлийн соёлыг бий болгох хэрэгтэй. Оролцогчидтой харилцан, хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлж, улсаас үзүүлж буй боловсролын тогтолцоонд олон талт платформыг санал болгох нь төрөл бүрийн мэдлэгийн үр шимийг хүртэхэд үр нөлөөтэй.

Юун түрүүнд Засгийн газрууд улсаас үзүүлж буй боловсролын тогтолцоонд инновацийг нэвтрүүлэхь тэжээх хэрэгтэй. Сайн сайхны төлөө тууштай байна гэсэн илгээлтийг түгээх хэрэгтэй. Суралцахуй болон түүнийг тодорхойлох хүчин зүйлсийг хянаж, тэргүүн туршлагууд нэвтэрч байгаа газарт үнэлгээ хийж, хэрэгжүүлэгчдэд туршлага солилцох, шинэ санаагаа туршиж, өргөжүүлэх боломж, нөөцөөр хангах.

Засгийн газар ч мөн төрийн бус оролцогч талуудаас суралцах ёстой. Боловсролын үйлчилгээнээс алслагдсан, эмзэг бүлгийн суралцагчдад заахад бие даасан, нөхцөл байдалд нийцсэн, уян хатан хандлагыг нэвтрүүлэх нь засгийн газрууд ашиг тус хүртэж болохуйц шинэ ойлголтыг төрүүлж, чадавх сул байгаа нь хувийн сургууль байтугай улсын сургуулиудыг зөв хянаж, үнэлэхэд саад болдог гэдгийг хүлээн зөвшөөрдөг.

Засгийн газрын үүрэг бол инновацийг бий болгох таатай орчныг бүрдүүлэх явдал юм. Боловсрол "үйлдвэрлэгчид" бусад үйлчилгээ үзүүлэгчдээс өрсөлддөг зах зээл хэмээн боловсролыг үзэж болохгүй. Үүний оронд шинэ санааг хуваалцах, туршиж үзэх, нотлогдсон тохиолдолд хэрэгжүүлэх, түүнийг боловсролын системээр түгээхэд нь төрөөс тусалж, эдийн засгийн зорилго гэхээсээ илүү нийтийн сайн сайхны төлөө сайн дурын төрийн бус оролцогч талуудтай хамтран ажиллах хэрэгтэй.

5. БОЛОВСРОЛЫН САЛБАРТ ОЛОН НИЙТИЙН МЭТГЭЛЦЭЭНИЙГ БИЙ БОЛГОХ БҮХИЙ Л ДУУ ХООЛОЙГ ТЭГШ БОЛОМЖООР ХАНГАЖ БАЙНА УУ?

Хувийн ашиг сонирхлыг таслан зогсооход улсаас үзүүлж буй боловсролын бодлогын үйл явцын ил тод, шударга байдлыг хангах



Бодлого боловсруулагчид бүх оролцогч талуудын үзэл бодол, хэтийн төлөвийг харгалзаж үзэх хэрэгтэй. Бодлого боловсруулагчид олон талын дуу хоолойд нээлттэй байх гэдэг утгаар боловсролын хууль тогтоомж, бодлого, зохицуулалтын талаар төрийн албан хаагчидтай ил тод харилцах нь чухал. Зарим оролцогч талууд нийтийн сайн сайхны төлөө бус зах зээлд эзлэх хувь, улс төрийн эрх мэдлээ нэмэгдүүлэхийн төлөө ажиллаж байх талтай.

Төрийн бодлогод нөлөөлөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор тулд хувийн ашиг сонирхлын лоббидолтын эсрэг засгийн газрууд хяналт тавьж, хамгаалах хэрэгтэй. Төрийн бодлогын үйл явцад итгэх итгэлийг хадгалахад улс төрийн намуудын хандив, төрийн өндөр албан тушаалтнуудтай хийх уулзалт, хувийн ашиг хонжоо олж болох албан тушаалд орохын тулд өмнөх ажлаа орхисон төрийн албан тушаалтнууд, төрийн албан тушаал хашиж буй лоббичид болон тэдний ивээн тэтгэгчдийн эсрэг зохицуулалтын тухай мэдээллийн эрх чөлөө, ил тод байдлыг дэмжих олон төрлийн арга хэмжээ авч болно. Эдгээр зөвлөмжүүд тэгш боломж, нийтийг хамарсан, оролцоог эрхэмлэдэг олон улсын байгууллага, төрийн бус оролцогч талуудыг оролцуулах тухай тодорхой бодлого шаардлагатай байна.

Тогтвортой хөгжлийн зорилго дахь боловсролын салбарын хяналт шинжилгээ

Тогтвортой хөгжлийн 2030 оны хөтөлбөрт хүрэх дунд хугацаа ойртож буй энэ цаг үед хяналт-шинжилгээний тогтолцоог боловсронгуй болгох, мөн улс орнууд дэвшүүлсэн зорилтуудаа хэрэгжүүлэх явцад чухал ахиц дэвшил гарч байна. Гэсэн хэдий ч КОВИД-19 цар тахлын улмаас дээрх үйл ажиллагаанд их хэмжээний сорилтууд тулгарсан. Боловсролын салбар дахь ахиц дэвшлийг хянах стандарт хэрэгслүүдэд нөлөөлсөн бөгөөд зорилтуудыг ч эргэн харахад хүргэж болзошгүй байна

УЛС ОРНУУД ТХЗ 4-ИЙН ҮНДЭСНИЙ ЖИШИГ ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙГ ТОДОРХОЙЛСОН


Боловсрол 2030 үйл ажиллагааны хүрээ баримт бичиг нь улс орнуудыг өөрийн анхны нөхцөл байдлыг харгалзан, дэлхийн нийтийн хөтөлбөрт оруулах хувь нэмрээ тодорхойлох зорилгоор ТХЗ 4-ийн шалгуур үзүүлэлтүүдийн "зохистой дунд хугацааны жишиг үзүүлэлт (жишээ нь 2020, 2025 он)" бий болгохыг уриалсан. Энэ хүрээнд ЮНЕСКО-ийн Статистикийн хүрээлэн болон Боловсролын хяналт-шинжилгээний дэлхийн тайлангийн багууд нь олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийг дайчилж, үйл ажиллагаанд татан оролцуулахаар ажилласан. 2019 онд жишиг тогтоох ТХЗ 4-ийн долоон шалгуур үзүүлэлтийг сонгон шалгаруулсан бөгөөд 2020 оны 10 дугаар сард зохион байгуулагдсан Дэлхийн боловсролын уулзалтын үеэр "ТХЗ 4-ийн үндсэн шалгуур үзүүлэлтүүдийн ахиц дэвшлийг эрчимжүүлж, хамаарал бүхий, бодитой жишиг үзүүлэлтүүдийг боловсруулах" зөвлөмжийг дэвшүүлснээр улс орнуудыг 2025 болон 2030 оны үндэсний хэмжээний жишиг үзүүлэлтийг боловсруулж, 2021 оны 10 дугаар сарын дотор ирүүлэхийг уриалсан. Улс орнуудын 39 хувь нь жишиг үзүүлэлтийг ирүүлсэн. Бусад 10 хувь нь жишиг үзүүлэлтийг ирүүлэх үүрэг хүлээсэн бол нэмэлт 14 хувь нь Европын холбоо болон Карибын улсуудын хамтын нийгэмлэгийн улс орнууд бөгөөд бүс нутгийн жишиг үзүүлэлттэй гишүүд юм. **(Зураг 3).**

2025, 2030 онуудад хүрэх суурь үнэлгээ болон улс орнуудын дэвшүүлсэн үндэсний хэмжээний харьцуулсан үнэлгээний талаарх мэдээллийг боловсролтой холбоотой мэдээлэлд нэвтрэх шинэ гарц болох Дэлхийн боловсролын ажиглалтад байршуулсан. ЮНЕСКО-ийн Статистикийн хүрээлэн болон БХШД тайлан нь эдгээр үйл ажиллагааны үр дүнд дүн шинжилгээ хийсэн суурь тайланг 2022 оны эхээр гаргах болно. Тус тайланд улс орнууд, бүс нутгууд, дэлхий нийтээр ямар хэмжээнд хүрсэн байхыг зорьж байгааг онцлон харуулна. Мэдээлэл бий шаардлагатай тохиолдолд КОВИД-19 цар тахлын болзошгүй үр нөлөөг үндэсний харьцуулсан үзүүлэлтүүдэд тусгахад тулсах үйл явцыг тоймлон харуулах болно

ЗУРАГ 3:

Гурван улсын хоёр нь ТХЗ 4-ийн жишиг үзүүлэлт тогтоох үйл ажиллагаанд оролцсон байна.

2021 оны 10 дугаар сарын байдлаар ТХЗ 4-ийн үндэсний жишиг үзүүлэлтийг өргөн мэдүүлсэн улс орнуудын эзлэх хувь



Холбоос: https://bit.ly/GEM2021_Summary_fig3
Эх сурвалж: ЮНЕСКО-ийн Статистикийн хэлтэс болон БХШД-ийн тайлангийн баг.

КОВИД-19 ЦАР ТАХАЛ НЬ ТХЗ 4-Д ХҮРЭХ ХЭТИЙН ТӨЛӨВ БОЛОН АХИЦ ДЭВШЛИЙГ ХЯНАХ АРГА ХЭРЭГСЭЛД НӨЛӨӨЛСӨН

КОВИД-19 бол дэлхийн бүх боловсролын тогтолцоог нэгэн зэрэг дайрсан хамгийн ноцтой хямрал юм. Сургуулиуд 2020 оны 3 дугаар сараас 2021 оны 10 дугаар сарын хооронд нийт хичээлийн өдрийн 28 хувьд хичээлийн үйл ажиллагааг хаасан бол 26 хувьд хэсэгчлэн хаасан байна. 2020 оны 4 дүгээр сард хичээлийн үйл ажиллагааг хаах шаардлага дээд цэгтээ (95%) хүрч байжээ. Харин 2020 оны 9 дүгээр сараас 2021 оны 8 дугаар сарын хугацаанд хичээлийн өдрүүдийн тал хувьд хичээлийн үйл ажиллагааг бүрэн эсвэл хэсэгчлэн хаасан **(Зураг 4).** Олон улс орнууд сургуулийн үйл ажиллагааг бүрэн хаасан хэдий ч хэсэгчлэн хаасан хэмээн ангилсан байна.

ТХЗ 4-ийн албан ёсны статистик нь ихэнх тохиолдолд 2019 оны үйл ажиллагааг хамарсан бөгөөд цар тахлын өмнөх нөхцөл байдлыг тусгасан байна. Статистикийн хүрээлэнгийн 2020 оны 6 дугаар сараас 9 дүгээр сарын хугацаанд боловсролын яамны 129 төлөвлөлтийн нэгжид хийсэн үнэлгээгээр нийт нэгжүүдийн гуравны хоёрын тайлагнах шаардлагыг хангах чадварт тодорхой хэмжээнд эсвэл хүндээр нөлөөлсөн тул мэдээлэл цуглуулах ажлыг хойшлуулах эсвэл дараачийн хичээлийн жилд хийж гүйцэтгэх шаардлагатай болсон байна. Цар тахлын улмаас судалгааны зохион байгуулалтад ч ноцтой нөлөөлсөн.

Зарим томоохон хэмжээний судалгааны хөтөлбөрүүд гар утасны судалгаанд шилжсэн. Гэвч 2020 онд төлөвлөсөн буюу хэрэгжиж байсан 25 гаруй судалгааны ажил хоцрогдож тодорхой саад бэрхшээлүүдтэй тулгарсан байна. Судалгааны ажил яг хэзээ хийгдэж, ойролцоох сургуулиудын үйл ажиллагаа нь тухайн үед нээлттэй байсан эсэхийг нарийн тооцоолох шаардлагатай. Үүнээс гадна сургалтын үнэлгээнд ч мөн нөлөөлсөн. Тухайлбал, 2021 оны Олон улсын сурагчийн үнэлгээний хөтөлбөрийг нэг жилээр хойшлуулсан байна.

Олон тооны эх сурвалж, арга зүй, жишээ, цаг хугацаа, нөхцөл байдлын ялгаатай байдал нь КОВИД-19 цар тахлын үр нөлөөний талаарх мэдээлэл цуглуулах ажил амаргүй болохыг илтгэж байна. Захиргааны мэдээлэл байхгүй тохиолдолд Эфиопи, Гана, Сенегал зэрэг улсуудад хийсэн судалгаагаар хүүхдүүд хичээлийн үйл ажиллагааг нээхэд сургуульд эргэн ирсэн тухай урьдчилсан мэдээлэл бий болсон хэдий ч анги улирах буюу давтах тохиолдол нэмэгдсэн нь сургууль завсардалтыг түр хойшлуулсан хэмээн үзэж байна.

Гол анхаарах хоёр асуудал бол суралцахуй тасалдсаны үр дагавар, сургалтын тасалдлын тэгш бус хуваарилалт болон бололцоо тааруу суралцагчдад үзүүлэх бусад нөлөө юм. Дэлхий даяар гурван хүүхэд тутмын нэг, эмзэг айл өрхийн зургаан хүүхэд тутмын нэг нь л интернетэд холбогдох боломжтой байна. Иймд боломжит зайн сургалтын хэлбэрүүдийн хамгийн үр дүнтэй хувилбар нь суралцагчдын дийлэнх хувьд хүрээгүй бөгөөд сургалтын эдгээр хэлбэрүүдийг өргөжүүлэх хүчин чармайлтууд нь богино болон дунд хугацаандаа сургалтын тэгш байдалд сөргөөр нөлөөлнө хэмээн үзэж байна. Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн анхаарлыг татсан гар утасны сургалтын аппликейшн нь Сахарын цөлөөс урагш орших Африкийн зургаан оронд явуулсан судалгаагаар хамгийн түгээмэл бус зайн сургалтын арга байсан бөгөөд Нигери Улсын хүүхдүүдийн 17 хувь, Эфиопи Улсын 12 хувь нь хэрэглэж, харин Бургина Пасо, Малави, Мали, Угандад зэрэг улсуудад бараг хэрэглэгдээгүй байна.

Сургалтад үзүүлэх нөлөө нь хичээлийн үйл ажиллагааг хаасан хугацаа, зайн сургалтын хэлбэр, сурагчдад үзүүлэх дэмжлэгийн цар хүрээ зэргээс хамаарна. Ихэнх судалгаанд өндөр орлоготой улс орнуудад хийсэн байна. Хичээлийн үйл ажиллагааг найман долоо хоногийн хугацаанд хаасан хэмээн үзэж, долоон гаруй орны дунджаар тооцвол сургалтын хоцрогдол математикийн хичээлийн хувьд нийт хичээлийн жилийн 30 хувь, унших хичээл хувьд 35 хувьтай тэнцэхээр байна. Харин Франц улсад 6 дугаар ангийн сурагчдын унших, математикийн хичээлийн дүн сайжирсан байна.

Нийгэм, эдийн засгийн байдлаас хамаарч нөлөөллийн хэмжээ харилцан адилгүй болохыг харуулсан тодорхой баримт бий. АНУ-ын 12 мужид 3-8 дугаар ангийн сурагчдын шалгалтын дүнд дүн шинжилгээ хийхэд танхимын хичээлээс холимог эсвэл бүрэн виртуал хэлбэрт шилжсэн нь сөрөг нөлөөллийн хэмжээг математикийн хичээлийн хувьд 10 хувь, Англи хэлний хичээлийн хувьд 4 хувиар нэмэгдүүлж байгааг харуулсан. Сургалтын холимог эсвэл виртуал хэлбэрт шилжсэнээр шалгалт давах чадвар өнгөт арьст болон испани гаралтай сурагчгүй дүүрэгт 4 хувиар, харин хүн амын 50 хувь нь өнгөт арьст болон испани сурагчтай дүүрэгт 9 хувиар буурсан байна.

Бага, дунд орлоготой орнуудад сургалтын шууд үнэлгээ хангалтгүй байдаг. Бразил Улсын Сан Пауло хотод ерөнхий боловсролын сургуулийн сурагчид цар тахал гараагүй тохиолдолд сургууль суралцах зүйлсийн дөнгөж 27.5 хувийг сурсан бол хичээлийн үйл ажиллагаа эргэн нээгдэж хичээлдээ орсон сурагчдын сургалтын хоцрогдол харьцангуй бага байсан. Колумб Улсад сурагчид өмнөх жилээс таван оноо доогуур үзүүлэлттэй байсан нь хичээлийн жилийн дөрөвний нэг орчим хувьтай тэнцэж байна. Өмнөд Африк Улсад 2 болон 4 дүгээр ангийн сурагчид цар тахлын өмнөх үеийнхэнтэй харьцуулахад 2020 онд унших чадварын хувьд хичээлийн жилийн 57-81 хувьтай тэнцэх хэмжээний хоцрогдолтой байна.

Боловсролын нөхцөл байдлын тайлангийн Өмнөд Азид хийгдсэн иргэдээр удирдуулсан үнэлгээ нь бага ангиудын сургалтын төвшин буурсан болохыг харуулж байна. Энэтхэг Улсын алслагдсан Карнатака мужид 2 дугаар ангийн төвшний текст унших чадвар бүхий сурагчдын хувь бүх ангийн сурагчдын хувьд буурсан

бөгөөд 2018-2020 оны хооронд 4-р ангийн сурагчдын хувьд хамгийн ихээр (33 хувиас 18 хувь хүртэл) буурсан байна. Пакистан Улсын 16 дүүрэгт хийсэн судалгаагаар 1 болон 3 дугаар ангиудын хувьд суурь ур чадварын ижил төстэй хоцрогдлыг илрүүлсэн боловч 5 дугаар ангийн хувьд хоцрогдол илрээгүй байна.

Эдгээр ялгаатай баримтуудыг нэгтгэж үзвэл хичээлийн үйл ажиллагааг хаасан нь сурагчдын сурлагад сөргөөр нөлөөлсөн болохыг баталж байна. Хоцрогдлыг ТХЗ 4-ийн ур чадварын доод төвшнөөр тодорхойлбол, цар тахлын нөлөөлөл нь анхны төвшин доогуур байсан бага орлоготой орнуудтай харьцуулахад дунд орлоготой орнуудад эсвэл хичээлийн үйл ажиллагааг маш богино хугацаанд хаасан буюу сурагчид цахим сургалтад хамрагдах боломж бололцоо өндөртэй өндөр орлоготой улс орнуудад илүү нөлөөлсөн байна. Гэсэн хэдий ч сургалтын төвшин дахин сэргэх эсэх, КОВИД-19 цар тахал суралцахуйд урт хугацааны нөлөө үзүүлэх эсэх зэрэг олон зүйлс тодорхойгүй хэвээр байна.


Улс орнууд цар тахлын үр дагаврыг бууруулах зорилгоор хичээлийн жилийг сунгах, сургалтын хөтөлбөрийн тодорхой хэсэг эсвэл тодорхой ур чадварыг онцолж чухалчлах арга хэмжээг авч байна. Улс орнуудын гуравны хоёр нь бага, дунд боловсролын төвшинд засан сайжруулах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байгаа тухай мэдээлсэн. Филиппин улсын Боловсролын газраас жилийн эцсийн шалгалтад 75 хувиас доош оноо авсан сурагчдад чиглэсэн зургаан долоо хоногийн нөхөн сэргээх хичээлийн удирдамжийг баталсан. Англи (Их Британи) Улсын Үндэсний багшийн хөтөлбөр нь 6 сая хүртэлх бололцоо тааруу сурагчдад зориулсан 15 цагийн нэмэлт сургалтын курсийг хэрэгжүүлж байна. Цар тахал нь **багш** нарт урьд өмнө хэзээ ч тулгарч байгаагүй бэрхшээлүүдийг учруулсан. Хичээлийн үйл ажиллагааг хааснаар олон багш зайн сургалтын хэлбэрт шилжихэд бэлтгэгдээгүй, өөрсдийн үүрэг ролийн талаар тодорхой ойлголтгүй, технологийн мэдлэг чадвар хангалтгүй байв. Нийт 165 орны 20,000 гаруй багш нарын дунд явуулсан судалгаагаар тэдний 39 хувь нь цар тахлын үеэр бие, оюун ухаан, сэтгэл санааны байдал нь доройтсон гэж хариулжээ. Нөгөө талаар, судалгаанд оролцогчдын 50 хувь нь ажилдаа илүү их урам зоригтой хандсан гэж хариулжээ. Цар тахлын хямрал нь багш нарын мэргэшлийн агуулгад шаардлагатай өөрчлөлтүүдтэй холбоотой асуудлуудыг хөндсөн. Технологийн мэдлэгээс гадна багш нар сурагчдын нийгэм-сэтгэл санааны болон эрдэм шинжилгээний шинэ хэрэгцээг хангах шаардлагатай болсон.

Тогтвортой хөгжлийн боловсрол, Дэлхийн иргэний боловсрол нь улам бүр харилцан уялдаатай болж буй хэдий ч ирээдүй нь эрсдэлд орсон дэлхийд учирж буй сорилтуудад үзүүлэх хариу арга хэмжээ юм. Гэсэн хэдий ч КОВИД-19 цар тахал нь боловсролын тогтолцооны эв нэгдэл, олон талт үзэл баримтлалыг баримталж чадаагүйг харуулсан бөгөөд улс орнуудын дотоод болон хоорондын тэгш бус байдал улам нэмэгдэж байгаа нь ёс суртахууны асуудлуудыг хөндөж байна. Вакцины үндсэрхэг үзлээс эхлээд гадны иргэд үзэл бодлын эсрэг бодлого, ялгаварлан гадуурхсан итгэл үнэмшил тархах зэрэг олон сөрөг хариу үйлдлийг бид харж байна. КОВИД-19 нь эрүүл мэндийн мэдлэг, боловсролын асуудлыг ч мөн анхаарлын төвд хүргэж байна.

ЗУРАГ 4:

20 гаруй сарын хугацаанд хичээлийн өдрүүдийн 55 хувьд хичээлийн үйл ажиллагааг хаасан байна.

2020 оны 2 дугаар сараас 2021 оны 10 дугаар сарын хооронд хичээлийн үйл ажиллагааг нээлттэй явуулсан өдрүүдийн эзлэх хувь, сараар



Холбоос: https://bit.ly/GEM2021_Summary_fig4
Эх сурвалж: ЮНЕСКО-ийн Статистикийн хүрээлэн (2021c).

Хичээлийн үйл ажиллагааг хааж, дахин нээх үйл явцын нийгмийн төвшин дэх халдварын динамик байдалд үзүүлэх цэвэр нөлөө нь тодорхойгүй хэвээр байна. Харин хувийн хамгаалах хэрэгсэл ашиглах, хүн хоорондын зай барих, гар угаахаас эхлээд эд зүйлсийг хуваалцахаас татгалзах, хүрсэн гадаргууг байнга халдваргүйжүүлэх арга хэмжээ авах замаар **сургалтын орчинд** халдварын эрсдэлийг багасгах боломжтой. Агааржуулалтыг сайжруулах бага технологийн шийдэлд гадаа талбай ашиглах, улирлын чанартай тохиолдолд цонх нээх зэрэг арга хэмжээ багтана. Бага орлого улс орнуудын 10 хүрэхгүй хувь нь бүх суралцагчид болон ажилчдын аюулгүй байдлыг хангахуйц хэмжээний саван, цэвэр ус, хувийн хамгаалах хэрэгсэл, ариун цэврийн болон эрүүл ахуйн хэрэгсэл зэргийг хангах үндсэн арга хэмжээг авч хэрэгжүүлсэн гэж мэдээлсэн бол өндөр орлоготой улс орнуудын 96 хувь нь тус арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

Цар тахал болон түүний үр дагавар нь Засгийн газрын орлого буурч, бусад салбарын эрэлт нэмэгдэж байгаатай холбоотойгоор боловсролын **санхүүжилтийг** бууруулахыг харуулсан зарим баримт илэрч байна. ЮНЕСКО-ийн Статистикийн хүрээлэнгийн 71 орноос цуглуулсан мэдээллээс харахад нийт зардалд боловсролын эзлэх дундаж хувь 2019 онд 14.1 хувь байсан бол 2021 онд 13.5 хувь болж буурсан байна.

Бага насны хүүхдийн боловсролын хувьд зайн сургалтыг хэрэгжүүлэх боломжтой тохиолдолд ч багш бэлтгэх сургалтын хангалтгүй байдал, зайн сургалтыг бага насны хүүхдэд зориулж тохируулах, хүүхдийн хөгжлийг хянах, үнэлэх, хангалттай дэмжлэг үзүүлэх боломжгүй, таагүй гэрийн орчинтой хүрч ажиллах зэрэг бэрхшээлүүд тулгардаг. Сургалтын байгууламжийн хаалт болон харилцаа холбооны хязгаарлагдмал байдал нь хүүхдүүдийн гэрийн орчноос гадуурх нийгэм, танин мэдэхүйн хөгжлийг хязгаарласан.

Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын хөтөлбөрүүдийн 80 хүртэлх хувь нь биечлэн эзэмших шаардлагатай практик болон зөөлөн ур чадварт төвлөрдөг тул тодорхой хүндрэл бэрхшээлүүдтэй тулгарсан. Стандарт боловсролын хөтөлбөрүүд тасалдсан энэ үед багш нарын зайн сургалт явуулах чадварыг нэмэгдүүлж, багш бэлтгэх асуудал гол асуудал байсаар ирсэн. Зайн сургалтыг явуулахад зөвхөн өндөр технологийн шийдэлд найдах бус олон арга хэлбэрийг ашиглах нь чухал юм. Үүний зэрэгцээ, сургалтын үйл ажиллагаа нь их хэмжээгээр саатсан салбаруудад дэмжлэг үзүүлсээр байгаа тэсвэртэй байдлын жишээ байдаг.

Дээд боловсролын түвшинд зайн сургалт явуулах чадвар бусад боловсролын түвшнөөс илүү байсан. Нийт 53 улсыг хамарсан судалгаанд хамрагдсан 3 улс дээд боловсролын цахим хэлбэрт бүрэн шилжиж, 19 нь анхнаасаа цахим сургалт явуулж байсан бол, 28 нь зайн болон танхимын сургалтын холимог аргыг ашигласан гэж мэдээлсэн. Колумб Улсаас Египет, Хятадаас Оросын Холбооны Улс хүртэлх дундаж орлоготой орнууд мөн цахим платформыг хөгжүүлсэн. Харин Сахарын цөлөөс өмнөх Африкийн оюутнуудын дунд явуулсан судалгаагаар ердөө 39 хувь нь зайн сургалтын сонголтыг санал болгодог байгууллагуудад элссэн байна. ЕХ-ны орнуудад суралцах хугацаандаа ажил эрхэлж байсан оюутнуудын 41 хувь нь ажлаасаа чөлөөлөгдсөн бөгөөд үүнээс 29 хувь нь түр хугацаанд, 12 хувь нь бүрмөсөн ажлаас чөлөөлөгдсөн байна.

Австрали, Шинэ Зеланд, Их Британи, АНУ зэрэг англи эх хэлтэй, олон улсын оюутнуудын зорьж очдог улс орнуудад чиглэсэн **оюутны шилжилт хөдөлгөөн** багассан байна. Австрали Улсад амьдарч буй оюутнуудын гуравны нэг нь олон улсын оюутнууд байдаг нь дээд боловсролын байгууллагуудад санхүүгийн эрсдэл учруулсан. Оюутнууд болон төгсөгчид эх орондоо буцаж ирэхийг хүлээх явцдаа суралцаж буй орондоо гацсан.

Насанд хүрэгчдийн бичиг үсгийн тайлагдал ба тоо бодох чадвар нь эрүүл мэндийн боловсрол, үр дүнтэй вакцинжуулалтын аянд чухал ач холбогдолтой бөгөөд олон нийтийн онцгой байдлын үед авах арга хэмжээ, сэргээн босголтын төлөвлөгөөний салшгүй хэсэг байх ёстой. Энэтхэг Улсад насанд хүрэгчдийн бичиг үсгийн хөтөлбөрт хамрагдсан эмэгтэйчүүд КОВИД-19 халдварт өвчний талаарх мэдлэг бичиг үсэг тайлагдаагүй иргэдийнхээс илүү байсан. Тоо бодох чадвар нь КОВИД-19 халдварт өвчний талаарх ташаа мэдээлэлд өртөмтгий байдлыг бууруулах хамгийн тогтвортой хэрэгсэл байсан. Гэсэн хэдий ч цар тахлаас өмнө ч зайн сургалт нь бичиг үсгийн боловсрол олгох анхан шатны хөтөлбөрүүдэд түгээмэл ашиглагддаггүй байсан. Бразил Улсад анхан шатны сургалтын хөтөлбөрт тохирсон ангиудад биеэр оролцох шаардлагыг тогтоосон журам байдаг.

ЗОРИЛТ 4.1. БАГА, ДУНД БОЛОВСРОЛ

Цар тахлын өмнө бага,дунд сургуулийн насны 260 сая хүүхэд,өсвөр үеийнхэн,залуучууд сургуулиас завсардсан байсан. Энэ үзүүлэлт арван жилийн хугацаанд бараг өөрчлөгдөөгүй. Захиргааны болон өрхийн судалгааны эх сурвалжийг нэгтгэх, гурвалжлах, захиргааны мэдээллийн цоорхойг нөхөх, уялдаа холбоотой цаг хугацааны цуврал боловсруулах зорилго бүхий БХШД тайлан болон ЮНЕСКО-ийн Статистикийн хүрээлэнгийн хамтарсан төсөл хэрэгжиж байна. Энэхүү үйл ажиллагааг төгсөлтийн төвшинг тооцоолох зорилгоор олон эх сурвалжийг нэгтгэсэн БХШД тайлангийн багийн ажилд түшиглэн зохион байгуулдаг. VIEW (www.education-estimates.org) хэмээх шинэ вэбсайт нь улс орнуудад хандах хандлагыг хялбаршуулж байна. Сахарын цөлөөс өмнөх Африкаас бусад бүх бүс нутагт бага боловсролын төгсөлтийн төвшин 90 буюу түүнээс дээш хувьд хүрсэн бөгөөд Сахарын цөлөөс өмнөх Африкийн бүсэд гурван хүүхдийн хоёр нь л бага сургуулиа төгсдөг байна. Харин төгсөх ангид хоцорч элссэн хүүхдүүдийг оролцуулж тооцвол төгсөлтийн төвшин 65%-аас 76% хүртэл нэмэгддэг байна. **(Зураг 5)**. Сахарын цөлөөс өмнөх Африкийн бүсэд бага сургуульд суралцаж буй хүүхдүүдийн 23 хувь, бага дунд сургуулийн өсвөр үеийнхний 31 хувийн нь нас хэтэрсэн байдаг нь тухайн бүс нутагт яагаад төгсөх хугацаанд болон эцсийн төгсөлтийн хоорондын зөрүү хамгийн их байгааг тайлбарлаж байна.

Олон улсын математик,шинжлэх ухааны чиг хандлагын судалгаанд (TIMSS) хамрагдсан дэлхийн улс орнуудын 2015-2019 оны хооронд ур чадварын доод төвшинд хүрсэн сурагчдын жилийн дундаж өсөлт 4-р ангид 0.3 пункт, 8-р ангид 0.5 пунктээр өссөн байна. Дээрх дунджаас өндөр үзүүлэлттэй орнуудад Чили Улс орсон бөгөөд 2003 онд жилийн дундаж 41 хувь байсан бол 2011 онд 57 хувь 2019 онд 70 хувь болж өссөн нь өсөлтийн хурд нь дунджаас дор хаяж 3 дахин хурдан байна. Иордан,Румын зэрэг бусад улсуудад өсөлт бага эсвэл огт ажиглагдаагүй. Сүүлийн 10 хувьд хүрэх нь нөөц сайтай нөхцөлд ч хэрэгжүүлэхэд амаргүй болох нь ажиглагдаж байна. TIMSS-ийн олон улсын доод харьцуулсан үзүүлэлтэд АНУ-ын сурагчдын 86 хувь нь 1995 онд, 87 хувь нь 2019 онд хүрсэн бол Шинэ Зеланд Улсад тус үзүүлэлтэд 89 хувь 1995 онд хүрсэн бол 2019 онд 82 хувь болж буурчээ.


ЗОРИЛТ 4.2. СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ

36-59 сартай хүүхдүүдийн бага насны хүүхдийн хөгжлийн индексийн мэдээллээс харахад хөрөнгийн ялгаа зогсонги байдалд орсон эсвэл нэмэгдсэн болохыг харуулж байна. Бага насны хүүхдийн эрүүл мэнд, суралцахуй,сэтгэц нийгмийн сайн сайхан байдлын хувьд хөгжлийн төвшинг тодорхойлдог энэхүү үзүүлэлтийн арга зүйг бүрэн шинэчилсэн. Суралцахуй нь гэрээс эхэлдэг. 2012-2019 онуудад бага, дунд орлоготой орнуудын хүүхдүүдийн 62 хувь нь гэрийн нөхцөлд насанд хүрсэн асран хамгаалагчийн хамт дөрөв ба түүнээс дээш төрлийн үйл ажиллагаанд оролцдог байв. Гамби, Сьерра-Леоне, Того улсуудад энэхүү үзүүлэлт нь 20 хувиас доош байсан. Хамт ном унших зэрэг үйл ажиллагааг идэвхжүүлэхэд тулгарч буй чухал хязгаарлалт бол номын хүртээмжийн асуудал юм.

ЗУРАГ 5:

Сургуулиа цаг тухайд нь төгсөх үзүүлэлт нь нэн ялангуяа Сахарын цөлөөс өмнөх Африкийн бүсэд сургуулиа төгссөн сурагчдын тоог дутуу үнэлдэг.

Төгсөлтийн төвшин ба эцсийн төгсөлт,бүс нутгаар,2000–20 он



Холбоос: https://bit.ly/GEM2021_Summary_fig5

Эх сурвалж: БХШД-ийн тайлангийн багаас өрхийн судалгааны мэдээлэлд хийсэн дүн шинжилгээ.

Дунджаар 5-аас доош насны хүүхдүүдийн дөрөвний нэг хүрэхгүй хувь нь гэртээ хамгийн багадаа гурван номтой байжээ. Улс орнуудын тал хувьд 10 хүүхэд тутмын 1-ээс бага нь гурван номтой бол Сахарын цөлөөс өмнөх Африкийн 8 оронд хүүхдүүдийн 1 хүрэхгүй хувь гурван номтой байна.

Хүний сурч боловсрох эрх нь төрсөн цагаас эхэлдэг. Хүүхэд 3 нас хүрэхэд тархины 90 хувь нь хөгжсөн байдаг. Дунд болон өндөр орлоготой хэд хэдэн улсад бага насны хүүхдийн асаргаа, боловсролын хөтөлбөрт хамрагдах нь 0-1 насныханд 20 гаруй хувь, 2 насанд 60 гаруй хувьд хүрдэг ч 3 хүртэлх насны хүүхдийн оролцоо хязгаарлагдмал байх хандлагатай байдаг. Өндөр орлоготой орнуудад ч бага насны хүүхдийн асаргаа, боловсролын хүртээмж нь нийгэм,эдийн засгийн нөхцөл байдлаас хамааралтай хэвээр байна. Франц, Ирланд улсуудад ядуу, чинээлэг өрхийн 0-2 насны хүүхдүүдийн оролцооны зөрүү 50 гаруй хувь байдаг. 2020 онд дуусах хичээлийн жилд дэлхийн хэмжээнд нийт хүүхдүүдийн 75 хувь нь цэцэрлэгт орох албан ёсны наснаасаа нэг жилийн өмнө сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан байна. Цэвэр элсэлтийн төвшин нь бага орлоготой орнуудын төвшин (45%) өндөр орлоготой орнуудтай (91%)харьцуулахад хоёр дахин өндөр байна.

ЗОРИЛТ 4.3. ТЕХНИК, МЭРГЭЖЛИЙН, ДЭЭД БОЛОН НАСАН ХҮРЭГЧДИЙН БОЛОВСРОЛ


Олон улс орнуудын хувьд ТМБС-ын санхүүжилт хангалтгүй,орхигдсон байдалтай байдаг хэдий ч Армен, Бразил, Бурунди, Коста Рика, Индонез, Уругвай зэрэг улсуудад сүүлийн 15 жилийн хугацаанд оролцооны хувь хэмжээг эрс нэмэгдсэн байна. Нийт улс орнуудын дөрөвний нэгийн хувьд мэргэжлийн диплом нь дээд боловсролын байгууллагад шууд үргэлжлүүлэн суралцах боломжийг олгодоггүйгээр ерөнхий боловсролын гэрчилгээнээс ялгаатай бөгөөд үүний улмаас мэргэжлийн дунд сургуульд суралцах нь сонирхол татахуйц сонголт хэмээн үздэггүй байна. Харин улс орнуудын 30 хувьд эсрэгээрээ, мэргэжлийн дунд сургуулийг төгсөгчид бүгд дээд боловсрол эзэмших боломжтой байдаг.

Дэлхий нийтийн дээд боловсролын элсэлтийн харьцаа 39 хувь байсан бөгөөд 2000 оноос хойш жил бүр 1 орчим хувиар тогтвортой өссөөр байна. Эдгээр захиргааны мэдээлэл нь ирцийн талаарх судалгааны өгөгдөлтэй тэр бүр нийцдэггүй **(Зураг 6)**. Хүлээн зөвшөөрөгдөөгүй эсвэл магадлан итгэмжлэгдээгүй улмаас албан ёсны статистикт тооцогдоогүй боловсролын байгууллагад элссэн олон тооны оюутнуудын ирцийг дутуу үнэлэх тохиолдол байдаг. Үүний эсрэгээр, олон оюутнууд

ЗУРАГ 6:

Дээд боловсролын элсэлтийн мэдээлэл нь бодит ирцийг хэтрүүлэн эсвэл дутуу үнэлэх тохиолдол бий.

Дээд боловсрол дахь нийт ирц,элсэлтийн харьцаа,2015–2019 онуудад



Холбоос: https://bit.ly/GEM2021_Summary_fig6

Эх сурвалж: ЮНЕСКО-ийн Статистикийн хүрээлэнгийн мэдээллийн сан.

зөвхөн нэрлэсэн хэлбэрээр элссэн бол, ялангуяа сургалтын төлбөр үнэ төлбөргүй, оюутны статус нь тэтгэмжийн үйлчилгээ үзүүлдэг тохиолдолд элсэлтийн хэмжээгээр ирцийг хэт өндөр үнэлж болзошгүй юм. Түүнчлэн, захиргааны мэдээлэл нь бүрэн дунд боловсролын сургууль төгссөнөөс хойших таван жилийн хугацааг хамруулдаг бөгөөд тус хугацаанаас хойш дээд боловсролд элсэх тохиолдол нэн ялангуяа Сахарын цөлөөс өмнөх Африкийн бүсэд түгээмэл байдаг.

Насан туршийн хэтийн төлөвөөс харахад дээд боловсрол эзэмших санхүүгийн боломж бүрдсэн хэдий ч тухайн боловсролыг урьдчилан эзэмших боломж хангалтгүй байдаг.

Дээд боловсролын зардал хуваалцах эдийн засгийн нөхцөл байдал нь зээлийн хязгаарлалтад ороогүй боломжит элсэгчдээс ихээхэн хамаардаг. Оюутны төрөл бүрийн зээлийн хэлбэрийг дэлхийн 70 гаруй оронд олгодог бөгөөд энэ нь нэг их наяд долларын зах зээл болон өргөжсөн байна. Олон улс орнуудад зээлдэгчийн оюутны зээлийг төлөхөд шаардагдах орлогын хэмжээ түүнээс зээлийн төлөлтийн эзлэх хувь маш өндөр бөгөөд ялангуяа амьдралын боломж тааруу төгсөгчдийн хувьд өрийн дарамт маш их байдаг. Өргөн хэрэглэгдэж буй зээлийн төлөлтийн хуваарьт суурилсан эргэн төлөлтийн хэлбэрээс орлогын нөхцөлд суурилсан эргэн төлөлтийн тогтолцоонд шилжих нь илүү ээлтэй бодлогын шинэчлэл болно.

Өндөр орлоготой ихэнх улс орнуудад ажил олгогчид насанд хүрэгчдийн боловсрол, сургалтын цорын ганц томоохон байгууллагатай байдаг нь хөдөлмөрийн зах зээлээс гадуур үлдсэн иргэдэд чиглэсэн бодлого шаардлагатай байгааг харуулж байна. Ажил эрхэлж буй иргэдийн хувьд ч сургалтад хамрагдах боломж буюу цаг хугацаа нь ивээн тэтгэх үйл ажиллагаанаас ялгаагүй , нэн чухал болох бөгөөд энэ нь боловсрол олгох хөтөлбөр хэлбэрээр олон нийтийн оролцоо шаардлагатайг харуулж байна. Өндөр орлоготой зургаан орны урт хугацааны мэдээллээс харахад насанд хүрэгчдийн боловсрол нь нийгмийн тодорхой бүлэг, ялангуяа боловсролтой иргэдийн хувьд байнга эрэлхийлдэг зүйл болохыг харуулж байна.

ЗОРИЛТ 4.4. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ УР ЧАДВАР

Мэдээлэл бүхий 91 улс орнуудын зөвхөн 10-д насанд хүрэгчдийн дийлэнх нь мэдээлэл, харилцаа холбооны технологийн (МХХТ) 9 ур чадвараас хамгийн багадаа 5 чадварыг дэлхийн хэмжээнд харьцуулах зорилгоор хянадаг гэж мэдээлдэг. Улс орны тал орчим хувьд насанд хүрэгчдийн дийлэнх нь ямар ч ур чадваргүй байдаг. Ихэнх бага,дунд орлоготой улс орнуудад бага дунд сургуулиа төгсөөгүй цөөхөн залуучууд МХХТ-ийн ур чадвартай байдаг. Ирак,Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улс, Сьерра-Леоне зэрэг улсуудын хамгийн боловсролтой иргэд ч есөн ур чадварын хоёроос ч багыг эзэмшиж байна. Тоног төхөөрөмж, интернетийн хүртээмжтэй байдал нь өөр нэг саад болж байна. Чад улсын 20-24 насны эмэгтэйчүүдийн 98 хувь, эрэгтэйчүүдийн 90 хувь нь хэзээ ч интернет ашиглаж байгаагүй гэж мэдээлсэн бол тус үзүүлэлт нь Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсад 61 хувь ба 63 хувь,Тунис Улсад 36 хувь ба 31 хувь байв.

Тооцооллын сэтгэлгээг сургалтын үндэсний хөтөлбөрт оруулж байна. Финлянд Улсад хүүхдүүд алгоритмын сэтгэлгээ, програмчлалын хичээлийг 1 дүгээр ангиас эхлэн хичээл хоорондын үйл ажиллагаа хэлбэрээр судлах шаардлагатай байдаг. Өндөр орлоготой найман орны 2018 оны тойм судалгаанаас үзэхэд хичээлийн үйл ажиллагаандаа МХХТ-ийг илүү түлхүү ашигладаг сурагчид бусад үе тэнгийнхнээсээ өндөр оноо авдаггүй бөгөөд програмчлалын ур чадвар эзэмшсэн сурагчид эдгээр ур чадвараа програмчлал шаардагдахгүй орчинд хөрвүүлэн ашиглах боломжгүйг харуулж байна.

Санхүүгийн мэдлэг нь орчин үеийн эдийн засаг болон насанд хүрэгчдийн амьдралд шаардагдах гол ур чадвар хэдий ч хүн бүр сургуульд суралцах хугацаанд санхүүгийн чухал ойлголтуудыг сурах боломжгүй байдаг. Олон улсын сурагчийн үнэлгээний 2018 оны хөтөлбөрт санхүүгийн мэдлэгийн нэмэлт загварыг багтсан бөгөөд үүнийг хөтөлбөрт оролцогч 20 боловсролын тогтолцоонд ашигласан. Санхүүгийн боловсролыг ихэвчлэн математикийн хичээл, сонгоны бус хичээлээр олгодог хэдий ч бүх оролцогч улс орнуудын хувьд санхүүгийн сэдэвтэй холбоотой ангийн үйл ажиллагаанд эмэгтэй сурагчдын оролцоо бага байсан

ЗОРИЛТ 4.5. ТЭГШ БАЙДАЛ

Өөр өөр төвшний харилцан адилгүй, өргөн хүрээний сорилтуулын талаарх ойлголт нь нарийн ньюансыг шаарддаг ч жендэрийн тэгш бус байдал гол асуудал хэвээр байсаар байна. Бүрэн дунд боловсрол нь өсвөр насны охидын хувьд таагүй үе байж болох ч (жишээ нь Бенин, Чад, Нигер улсуудад) давуу талыг эдэлж, нөхцөл байдлыг богино хугацаанд өөрсдөдөө ашигтайгаар өөрчлөгдөх боломж бүхий боловсролын төвшин юм. Энэ нь бусад улс орнуудтай харьцуулахад ТХЗ 4-т хүрэхэд хамгийн хол байгаа Камбож, Конго, Гамби, Гана,Малави,Руанда зэрэг тодорхой бүс нутаг дахь улс орнуудад ч тохиолдож байна.

Хүүхэд бүрийн өөрийн онцлогт хамаарсан хэрэгцээг (өрхийн төвшинд хэмжигддэг) хөрөнгөөр тэр бүр шийдэж чаддаггүй. Хэд хэдэн улс оронд дутагдалд өртсөн хүүхдүүдийн 10 хувь нь чинээлэг өрхөөс гаралтай байдаг бол хамгийн эмзэг өрхийн 30 гаруй хувь нь хэрэгцээ, дутагдалтай тулгараагүй байна. Хүүхдийн дутагдлын төвшин нь боловсролын ур дүнгийн нэмэлт чухал мэдээлэгч байж болно.

Багагүй тооны хүүхдүүд төрийн бус зэвсэгт бүлэглэлүүдийн хяналт бүхий сургуулиудад суралцдаг. Эдгээр бүлгүүдэд шууд хяналт хийх, сургалтын хөтөлбөрт оролцох, эсвэл одоогийн үйлчилгээ үзүүлэгчдийг үргэлжлүүлэн ажиллуулах зэрэг сонгомол оролцоогоор дамжуулан боловсрол олгох олон шалтгаан бий. Боловсрол бол иргэдийн хамгийн эрэлт хэрэгцээтэй,үнэтэй үйлчилгээний нэг бөгөөд боловсрол олгож чадаагүй тохиолдолд олон нийтийн дургүйцлийг төрүүлэх хандлага байдаг.

Боловсролд хэл шинжлэлийн олон янз байдлын асуудал, бэрхшээлүүпд тулгардаг. Чад, Гамби, Того зэрэг баруун болон төв Африкийн орнуудад 7-14 насны хүүхдүүдийн 5-аас илүүгүй хувь нь сургалт олгож буй хэлээр гэртээ ярьдаг. Сургалтын бодлогын хэлийг хэлний мэдээллийн эх сурвалж, сургуулийн насны хүн амын тооцоолол, элсэлтийн түвшинтэй хослуулсан арга барил нь бага, дунд орлоготой орнуудын хүүхдүүдийн 37 хувь нь эх хэлээсээ өөр хэлээр сурдаг болохыг харуулж байна. Үүнд 27 хувь нь бичгийн цөөнх хэлээр, 10 хувь нь бага нийтлэг хэлээр ярьдаг байна.

ЗОРИЛТ 4.6. БИЧИГ ҮСЭГ ТАЙЛАГДАЛТ, ТОО БОДОХ ЧАДВАР

Дэлхийн хэмжээнд 15 ба түүнээс дээш насны насанд хүрэгчдээс эмэгтэйчүүдийн 83 хувь, эрэгтэйчүүдийн 90 хувь нь бичиг үсэгт тайлагдсан бөгөөд бичиг үсэг тайлагдсан байдлыг хоёртын ангиллаар авч үзвэл 7 пунктийн зөрүүтэй байна. Сахарын цөлөөс өмнөх Африкийн бүс нутагт дөрвөн залуу эмэгтэй тутмын нэгээс илүү нь бичиг үсэг тайлагдаагүй байдаг бөгөөд залуу эмэгтэй хүмүүсийн бичиг үсэг тайлагдсан байдал жил бүр нэг пунктээр өссөөр байна. Дэлхийн хэмжээнд 1999 оноос хойш Зүүн болон Зүүн өмнөд Азийн орнуудад бичиг үсэг тайлагдаагүй эмэгтэйчүүдийн тоо буурсан нь Сахарын цөлөөс өмнөх Африкт нэмэгдэж буйгаар нөхөгдөж байна. Нэмж дурдахад, ерөнхий боловсролын сургуулийн төгсөгчид бүгд бичиг үсэг тайлагдсан хэмээн үздэг нь бичиг үсэг тайлагдлын бодит төвшинг өмнө нь хэт өндөр үнэлж ирснийг харуулж байна. Сүүлийн үеийн судалгаанд хамрагдсан 18 орны дунд боловсрол эзэмшсэн хүүхдүүдийн бараг тал хувь нь энгийн өгүүлбэр унших чадвартай гэж тодорхойлсон нь бичиг үсгийн анхан шатны төвшинд хүрээгүй байна. **(Зураг 7)**.


Харин эсрэгээрээ ямар нэгэн сургуульд хамрагдаагүй болохыг бичиг үсэг тайлагдаагүй хэмээн ойлгож болохгүй бөгөөд сургуулиас гадуур бичиг үсгийн боловсрол эзэмшихийн ач холбогдлыг харуулж байна. Тооцоолж буй бичиг үсэг тайлагдаагүй хүн амын тооноос авч үзвэл, Боловсролын олон улсын стандартын ангилал 1-ийн албан бус хөтөлбөрт хамрагдах насанд хүрсэн хүн Болив, Гондурас, Мозамбик, Катар, Суринам улсуудад 1ба түүнээс бага хувь, Бахрейн, Перу улсуудад 2 хувь, Колумб, Тайланд улсуудад 3 хувь, Саудын Араб улсад 4хувь Доминикан улсад 8 хувь байна.

Тоо бодох энгийн ур чадварын талаарх мэдээлэл ч ховор байдаг. Суурь тоо тооллын ойролцоо хэмжигдэхүүнийг тэдний насыг зөв илэрхийлсэн хувиар тооцож болох бөгөөд энэ нь энгийн, бага бүхэл тоо бодох чадварыг илэрхийлдэг. Хэдийгээр ихэнх хүмүүс, тэр байтугай хамгийн эмзэг бүлгийн иргэд ч энэ босгыг давдаг ч энэ хэмжүүр нь тоо тооллын түүхэн хандлагыг судлахад илүү тохиромжтой юм. Өрхийн судалгаа, хүн амын тооллогын мэдээлэлд дүн шинжилгээ хийснээр 1960-2010-аад оны хооронд төрсөн хүмүүсийн тоог Сахарын цөлөөс урагш орших Африкийн бүсийн 42 орны тоогоор тодорхойлох боломжтой. Цаг хугацаа өнгөрсөн ч сайжрах байдал бага байсан бөгөөд хамгийн эмзэг бүлгийн хүмүүсийн хувьд тогтвортой хадгалагдсангүй. Африкийн бүсэд тоо бодох чадвар өссөн нь бүхэлдээ сургуулийн оролцоо нэмэгдсэнтэй холбоотой юм.

ЗУРАГ 7:

Ерөнхий боловсролын сургууль төгсөгчдийг ч бичиг үсгийн боловсрол эзэмшсэн хэмээн үзэж болохгүй.

20-24 насны хүмүүсийн бичиг үсгийн боловсролын төвшин, сургуулийн амжилтаар, сонгогдсон орнуудад, 2015–19 онуудад



Санамж: Цэгийн хэмжээ нь хүрсэн төвшин бүрийн хүн амын тоотой пропорциональ байна.
Холбоос: https://bit.ly/GEM2021_Summary_fig7
Эх сурвалж: БХШД тайлангийн багаас Хүн ам зүй,эрүүл мэндийн судалгааны өгөгдөлд хийсэн дүн шинжилгээ

ЗОРИЛТ 4.7. ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ БА ДЭЛХИЙН ИРГЭНШИЛ

Зорилт 4.7 нь ТХЗ 4-ийн өөрчлөлтийн зорилгод хүрэхэд суралцагчид юу сурах ёстойг шийдвэрлэхэд ТХЗ 4-ийн бусад зорилтоос илүү тодорхойлж байна. Амьдрах үр чадварт суурилсан, ХДХВ, бэлгийн боловсрол олгодог сургуулиудын эзлэх хувь ялангуяа бага ангиудад цөөн байдаг бөгөөд Бургина Пасо Улсын бага сургуулиудын 2.5 хувь,Нигери Улсад 6 хувь байна. НҮБ-ын шинэчлэн найруулсан Бэлгийн боловсролын олон улсын арга зүйн удирдамжид суралцагчдыг бэлгийн бойжилт явагдах болон сарын тэмдэг ирэхээс өмнө, өөрөөр хэлбэл 9-12 насны сурагчдыг хамруулахыг зөвлөсөн байна. ЮНЕСКО-ийн Бэлгийн боловсролын тойм, үнэлгээний хэрэглүүр нь бэлгийн цогц боловсролын талаарх сүүлийн үеийн дэлхийн ахиц дэвшлийн тайлан юм. 24 улсаас ердөө 3 нь 9-12 насны сурагчдад бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаар ахисан төвшний сургалтын агуулгатай, 5 улс нь "тогтсон" агуулгатай гэж мэдээлсэн байна.

Дундаас дээш болон өндөр орлоготой 23 оронд хийсэн Олон улсын иргэний болон иргэншлийн боловсролын 2016 оны судалгаагаар дэлхийн иргэншилтэй холбоотой асуудлын талаар хангалттай ойлголттой сурагчдын эзлэх хувь Доминикан, Латви, Нидерланд улсуудад 40 орчим хувь, Хорват, БНСУ, Швед улсуудад 70 орчим хувьтай байгааг тогтоожээ. 2019 оны Олон улсын математик, шинжлэх ухааны судалгааны чиг хандлага нь сурагчдын дөнгөж 30 орчим хувь нь байгаль орчны шинжлэх ухааны мэдлэгийн хангалттай төвшинд хүрсэн болохыг харуулсан. Уур амьсгалын өөрчлөлтийн боловсрол нь хүн амд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг ойлгох, шийдвэрлэх, бууруулах, дасан зохицоход нь дэмжлэг үзүүлэх зорилготой. БХШД-ийн тайлан болон Уур амьсгалын харилцаа холбоо, боловсролын хяналт-шинжилгээ, үнэлгээний төслөөс боловсруулсан уур амьсгалын өөрчлөлтийн харилцаа холбоо,боловсролын талаарх улс орны шинэ цуврал профиль нь харьцуулсан хэтийн төлөвийг агуулдаг. Эхний багц 20 улс орны профиль нь бүх бүс нутаг, улс орны орлогын бүлгийг хамардаг. 50 хүртэлх улсын профиль бүхий хоёр дахь багцыг 2022 онд нийтлэхээр төлөвлөж байна. Анхны дүн шинжилгээгээр боловсролын тухай үндэсний хууль тогтоомжийн дөнгөж 40 хувь, боловсролын салбарын төлөвлөгөө, стратегийн 45 хувь нь уур амьсгалын өөрчлөлтийн асуудалд анхаарсан байна.

ЗОРИЛТ 4.А. БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛАМЖ, СУРГАЛТЫН ОРЧИН

Сургалтын орчин нь тохиромжгүй, хүүхдийн сайн сайхан байдалд сөргөөр нөлөөлсөн тохиолдолд сайн чанарын мэдлэгийг олж авах боломжгүй байдаг. Зэвсэгт мөргөлдөөний үед сурагч, багш, сургууль, их дээд сургуулиудыг халдлагаас хамгаалахад чиглэсэн Засгийн газрууд хоорондын улс төрийн амлалт болох "Аюулгүй сургуулиудын тунхаг"-ыг өдгөө 112 муж улс дэмжин баталсан байна. Бие махбодийн шийтгэл нь хүүхдийн эрхийг зөрчөөд зогсохгүй боловсролын үр дүнд нөлөөлдөг болохыг үзүүлсэн баримт баримт нэмэгдсээр байна. Өнөөгийн байдлаар дэлхийн 156 орны сургуулиудад бие махбодийн шийтгэлийг бүрэн хорихложээ.

Сургууль бол зарим хүүхдүүдийн хувьд ус, эрүүл ахуй, ариун цэврийн байгууламжийг ашиглах боломжтой цорын ганц газар байх тохиолдол цөөнгүй байдаг. Либери Улсад цөөн тооны айл өрх олон улсын стандартад нийцсэн ариун цэврийн байгууламжтай байдаг ч сургуулиудын 69 хувь нь эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн өрөөтэй байдаг. Гэсэн хэдий ч,алслагдсан,хөдөө орон нутагт байрладаг жижиг сургуулиуд нь том сургуулиудтай харьцуулахад дэд бүтцийн чанарын шалгуурыг хангах магадлал бага гэж үзэж болно. Кабо Верде мужид 2018 онд бага сургуулийн 22 хувь нь гар угаах үндсэн хэрэгсэлгүй байв. Харин жижиг хэмжээний бага сургуулийн 22 хувь нь бага сургуулийн элсэлтийн дөнгөж 2 хувийг эзэлж байсан. Дэлхийн хэмжээнд наад захын байгууламжгүй сургуульд сурч байгаа хүүхдүүдийн эзлэх хувь сургуулийн эзлэх хувьтай харьцуулахад хамаагүй бага байх магадлалтай.

Материаллаг байгууламжаас гадна, хичээлийн өдрүүдийг долоо хоног, жилээр төлөвлөхөөс авахуулаад хичээлийн өдрийн үргэлжлэх хугацаа,зохион байгуулалт зэрэг сургуулийн хуанли төлөвлөх зэрэг үйл ажиллагаа нь боловсролын тогтолцооны чанар, тэгш байдалд чухал үр нөлөө үзүүлдэг. Олон улс орны сургуулийн хуанлийн бүтэц нь улирлаас илүүтэйгээр колоничлолын түүхийн нөлөөллөөс шалтгаалдаг бөгөөд орон нутгийн хөдөө аж ахуйн мөчлөгтэй тэдийлэн нийцдэггүй байна. Хичээл эхлэх цаг бас чухал ач холбогдолтой. Хичээл хожуу цагаас эхлэн нь илүү унтах хугацаа олгохоос гадна өсвөр насны сурагчид өглөө эрт гэхээс оройн цагт хамгийн их сэргэг,үр бүтээмжтэй байдаг тул тэдний өдөр тутмын хэмнэлтэй илүү сайн зохицдог.

ЗОРИЛТ 4.В. ТЭТГЭЛЭГ

Оюутны шилжилт хөдөлгөөнийг дэмжих нийт тусламжийн хэмжээ 2015-2019 оны хугацаанд 30 хувиар өсөж, 3,4 тэрбум ам.доллараас 4,4 тэрбум ам.доллар хүрсэн байна. 2015 оноос 2019 оны хооронд бага орлоготой орнуудад үзүүлэх тэтгэлгийн нийт хэмжээ хоёр дахин нэмэгдэж, дээд сургуульд элсэгчдийн өсөлтөөс давсан байна. Гэхдээ бага болон дунд орлоготой орнуудын аль алиныг нь харгалзан үзэхэд гадаадад улсад суралцаж буй оюутнуудын тоо тэтгэлгийн тусламжийн өсөлтөөс хол давсан байна. 2019 онд олон улсын оюутанд ногдох тэтгэлгийн дундаж хэмжээ 2006 онтой харьцуулахад буурсан байна. 2020 он гэхэд тэтгэлгийн хэмжээг мэдэгдэхүйц нэмэгдүүлэх зорилт биелээгүй байгааг жигд бус тоо баримт харуулж байна. Харин хандивлагчид 2015 онтой харьцуулахад хөгжиж буй орнуудад тэтгэлэг олгох нь илүү болсон бөгөөд хүлээн авагч орнууд нэг эсвэл хоёр гол хандивлагчаас хараат байх магадлал буурч байгаа нь гол үзүүлэлт болж байна.

Тэтгэлгээр суралцагчид эх орондоо буцаж ирдэггүй "тархины хоосрол" үүсэх ойлголт "тархины эргэлт" хэмээх илүү боловсронгуй ойлголтоор солигдож байна. Сүүлийн үеийн тооцооллоор харахад эх орондоо эргэн ирсэн хөдөлгөөн нь Сахарын цөлөөс өмнөх

Африк болон Латин Америк руу чиглэсэн шилжилт хөдөлгөөний дийлэнх хэсгийг эзэлсэн бөгөөд эдгээр цагаачдын боловсролын дундаж төвшин өндөр байдаг. Зарим улс орнууд ойрын хугацаанд эх орондоо эргэн ирэхгүй өндөр ур чадвартай иргэдийг ч тус улсын хөрөнгө хэмээн хүлээн зөвшөөрдөг. Цагаачлалын бодлогын индексээр дүн шинжилгээ хийсэн Латин Америк, Карибын тэнгисийн 22 орноос 8 нь оюуны эргэлтийн сүлжээг хэвийн явуулж байна. Дэлхийн бүх бүс нутаг, орлогын төвшин, засгийн газрын төрлүүдийг төлөөлсөн 35 орны диаспорагийн бодлогын өмнөх зураглалаас үзэхэд улс орнуудын гуравны хоёр нь ямар нэгэн төрлийн шинжлэх ухааны сүлжээг хадгалж, гадаад руу тэтгэлгээр явсан оюутнуудын тал хувь буцаж ирэх үүрэг хүлээдэг болохыг тогтоожээ.

ЗОРИЛТ 4.С. БАГШ НАР

Тайланд өгөгдсөн мэдээллээс харахад Сахарын цөлөөс өмнөх Африк нь үндэсний стандартад нийцсэн багш нарын тоо хамгийн цөөнтэй бүс нутаг болох буюу сургуулийн өмнөх боловсролын багш нарын 57 хувь (Латин Америк ба Карибын тэнгисийн орнуудад 83 хувь), бага ангийн багш нарын 67 хувь (Хойд Африк болон Баруун Азид 85 хувь), дунд боловсролын багш нарын 61хувь (Төв болон Өмнөд Азийн орнуудад 78хувь) үндэсний стандартыг хангаж байна. Иймд 2015 оноос хойш дээрх үзүүлэлт бага зэрэг нэмэгдсэн хэдий ч сурагч/сургагч багшийн харьцаа Сахарын цөлөөс өмнөх Африкт дэлхийн дунджаас бараг хоёр дахин өндөр байна.

Мэргэшсэн багш нар ч зааж буй хичээлдээ тэнцэхгүй байх тохиолдол байдаг. Мэргэшсэн салбараас гадуур хичээл заах нь дэлхийн ихэнх улс оронд түгээмэл байдаг. 2018 оны Заах ба суралцахуйн олон улсын судалгаанд оролцсон 40 орчим боловсролын системийг хамруулан судлахад сургуулийн байгалийн ухааны багш нарын 10 гаруй хувь нь зааж буй сэдвээрээ албан ёсны боловсрол, сургалтад хамрагдаж байгаагүй байна. Математикийн багш нарын хувьд ч мөн адил. Гүрж, Саудын Араб улсуудад шинжлэх ухаан, математикийн багш нарын 60 хүрэхгүй хувь нь албан боловсролынхаа хүрээнд тухайн хичээлийн сургалтад хамрагдсан байна. Салбараас гадуур багшлах нь тэгш байдлын асуудлуудыг үүсгэдэг. Учир нь хүн бүр салбараас гаднах багш байх, эсвэл сурагчдын хувьд бусад салбарын багшаар хичээл заалгах магадлал адилгүй байдаг бөгөөд энэ нь ихэвчлэн хөдөө орон нутгийн болон бололцоо муутай сурагчдад тохиолддог.

Харьцуулж болохуйц мэргэшил шаарддаг бусад мэргэжлүүдтэй харьцуулахад багш нар хэрхэн үнэлэгдэж байгааг судалдаг ЮНЕСКО-ийн Статистикийн хүрээлэнгийн багшийн цалингийн үзүүлэлтийн шинэ тооцоо нь нэг улсын олон төрлийн боловсролын төвшний багш нарын дундаж ялгаа нь улс орнуудын хоорондын ялгаатай харьцуулахад ерөнхийдөө бага байгааг харуулж байна. Ихэнх нотолгоонуудыг авч болох өндөр орлоготой орнуудад багш нар бусад салбарын мэргэжилтнүүдтэй харьцуулахад цалин бага авдаг байна. **(Зураг 8).**

Багшийн цалингийн үзүүлэлт нь багшийн урам зоригийг илэрхийлэгч байх зорилготой. Харин зүүн болон өмнөд Африкийн найман оронд багшийн ажил тасалдсан байдалд хийсэн сүүлийн үеийн дүн шинжилгээнээс харахад багшийн урам зоригт өөр олон хүчин зүйл нөлөөлдөг байна. Багш нарын өөрсдийнх нь мэдээлснээр долоо хоногт хамгийн багадаа нэг удаа ажил тасалдаг хүмүүсийн эзлэх хувь Кени, Руандад улсуудад10 хувиас бага, Өмнөд Судан Улсад бараг 30 хувь хүртэл байна. Багш нар эрүүл мэнд (62 хувь), гэр бүл (35 хувь), цаг агаар (ялангуяа аадар бороо, хэт халалт), албан ажил, тээврийн асуудлын шалтгаанаар ажил тасалсан гэж мэдээлдэг.

БУСАД ТХЗ-ЫН БОЛОВСРОЛЫН АСУУДЛУУД

Өрх гэрийн эрчим хүчний хүртээмж нь хүүхдүүдэд боловсролын үйл ажиллагаанд оролцоход чухал үүрэг гүйцэтгэдэг. Бутан Улсын хөдөө тосгонуудыг цахилгаанжуулах хөтөлбөр нь түлшний модны хэрэглээг багасгахад тусалж, 0.8 жилээр илүү суралцахад хүргэсэн нь охидод хөвгүүдээс илүү хүчтэй нөлөөлсөн. Сургуулийн эрчим хүчний хүртээмж нь сургалтын орчныг сайжруулах, сургалтын нөөцийн хүртээмжийг өргөжүүлэхэд тусална. Эрчим хүчний салбарын менежментийн тусламжийн хөтөлбөрөөс Кени Улсын сургуулиудын 72 хувь, Эфиопи Улсын дөнгөж 22 хувь нь нийтийн сүлжээнд холбогдох боломжтой болохыг тогтоожээ. Зам тээврийн хөгжил нь ядуурлыг бууруулах, эдийн засаг, нийгмийн хөгжил, тэр дундаа боловсролын үр дүнг дэмжихэд тусалдаг. Колумб Улсын Антиокиа хэлтэст хөдөө орон нутгийн замуудыг сайжруулсан нь хөдөө орон нутгийн сурагчдын боловсролын гүйцэтгэл сайжрахад нөлөөлсөн байв.

2030 онд ТХЗ-д хүрэх зорилгын явцад нар, салхины эрчим хүчний хэрэглээнд шилжих томоохон хөрөнгө оруулалтаар дэмжигдсэн сэргээгдэх эрчим хүчний технологийг сайжруулахад магтуушстай ахиц дэвшил гарч байна. Тогтвортой хэрэглээ үйлдвэрлэл шаардлагатай хэмээх ойлголт ч нэмэгдэж байна. Гэсэн хэдий ч хүнс бэлтгэх технологийн тэгш хүртээмж, чадавхыг бэхжүүлэх зорилгоор буурай хөгжилтэй орнуудад санхүүгийн тусламж үзүүлэх, олон талт, тэгш ажиллах хүчний хөгжил зэрэг зах зээлд чиглээгүй зорилтуудын нөхцөлийг сайжруулах нь бэрхшээлтэй хэвээр байна. Боловсрол нь тогтвортой байдлын зорилгод хүрэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ. Боловсролын байгууллагууд сурагчдын эрчим хүч болон бусад тогтвортой байдлын асуудлуудын талаарх мэдлэг, ойлголтыг дэмжих шаардлагатай. Олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлснээр нийгмийн өргөн хүрээг хамарсан өөрчлөлтөд хувь нэмэр оруулна. Мөн ногоон шилжилтийг дэмжихэд мэргэжлийн чадавхыг хөгжүүлэх ажлыг урьд өмнө байгаагүйгээр хурдацтай явуулах шаардлагатай байна.

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

Төсвийн нийт зардалд боловсролын эзлэх хувь 2000 онд 13.8 хувь байсан бол 2019 онд 14.1 хувь болж өссөн. 71 орны сүүлийн үеийн мэдээллээс харахад 2021 онд 13.5 хувь болж буурсан нь КОВИД-19 цар тахлын нөлөөлөл хүчтэй байгааг харуулж байна. 2014-2019 оны мэдээлэлд 151 улсаас 48 буюу 32 хувь нь ДНБ-ий 4 хувь,Засгийн газраас боловсролын салбарт зарцуулах зардлын 15 хувь гэсэн шалгуур үзүүлэлтийн аль алийг хангаж чадаагүй байна. Зарим улс орнууд хамгийн эмзэг бүлгийн иргэдэд чиглэсэн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд нэлээд үр дүнтэй байдаг. Алжир Улс бага,дунд сургуулийн 3 сая сурагчдад жил бүр 23 ам. доллартай тэнцэх боловсролын тэтгэмж олгодог бөгөөд үүнээс эмзэг бүлгийн 38 хувь, харин хамгийн чинээлэг бүлгийн иргэдийн 10 хувьд нь ногддог байна.


2019 онд боловсролын салбарт үзүүлэх тусламж 15.3 тэрбум ам.доллар хэвээр байна. Тусламжийн ашиг тус нь хүмүүст харилцан адилгүй хэлбэрээр хүрдэг. Нэг тодорхойлолт нь улс орны өмчлөл ба үр дүн, ил тод байдал, харилцан хариуцлага, бүгдийг хамарсан хөгжлийн түншлэлд төвлөрдөг. Төсвийн шууд дэмжлэгийн нийт тусламжид эзлэх хувь 2002 онд 6.6 хувь байсан бол 2019 онд 2.5 хувь болж буурчээ.

2010 онд бага, дунд орлоготой 100 орчим орны өрхийн төсвийн судалгааны тайланд хийсэн дүн шинжилгээгээр өрхийн нийт зардлын 3.2 хувийг боловсрол эзэлж,Гаити, Ливан болон Руанда, Угандад, Замби зэрэг Сахарын цөлөөс өмнөх Африкийн орнуудад 6 ба түүнээс дээш хувийг эзэлж байгааг тогтоосон байна.

ЗУРАГ 8:

Бусад мэргэжлийн хүмүүстэй харьцуулахад өндөр орлоготой орнуудад багш нарын цалин харьцангуй бага боловч бага, дунд орлоготой зарим орнуудад цалин өндөр байна.

Харьцуулж болохуйц мэргэшил шаарддаг бусад мэргэжилтэй харьцуулсан багшийн дундаж цалин, 2015–19 онуудын хооронд



Холбоос: https://bit.ly/GEM2021_Summary_fig8

Эх сурвалж: ЮНЕСКО-ийн Статистикийн хүрээлэнгийн өгөгдлийн сан.

Боловсролын салбар дахь төрийн бус оролцогч талууд:

ХЭН СОНГОЖ, ХЭН АЛДАХ ВЭ?

Төрийн бус оролцогч талуудын үүрэг нь сургуулиас гадна боловсролын салбарын харилцан адилгүй төвшний оролцоо, нөлөөллийн хүрээг хамардаг. 2021/2022 оны Боловсролын хяналт-шинжилгээний дэлхийн тайланд ТХЗ 4-т хүрэх ахиц дэвшлийг тоймлож, КОВИД-19 цар тахлын нөлөөг харуулсан баримтуудыг танилцуулахын зэрэгцээ бүх байгууллага, сурагч, багш нарыг нэгэн тогтолцооны нэг хэсэг болгон авч үзэхийг Засгийн газруудад санал болгож байна. Стандарт, мэдээлэл, урамшуулал, хариуцлага нь Засгийн газруудад эрх ямба, мөлжлөгийг үл харгалзан бүх хүний боловсрол эзэмших эрхийг хангах, хүндэтгэх, биелүүлэхэд чиглэсэн байх ёстой. Төсвөөс санхүүждэг боловсролыг ниитэд олгох шаардлагагүй ч боловсролын үйл явц, сурагчийн үр дүн, багшийн ажлын нөхцөл дэх ялгааг арилгах ёстой. Үр ашиг, инновацийг арилжааны нууц гэхээс илүүтэй бусдад түгээж, бүх нийтээр хэрэгжүүлэх шаардлагатай. Ингэхдээ хувийн ашиг сонирхлыг арилгахад нийтийн боловсролын бодлогын үйл явц дахь ил тод, шударга байдлыг хангах хэрэгтэй.

"Хэн сонгож, хэн алдах вэ?" хэмээх энэхүү тайлангийн уриа нь бодлого боловсруулагчид дараах үндсэн сонголтуудын хүрээн дэх төрийн бус оролцогч талуудтай хамтран ажиллаж буй харилцаагаа дахин эргэн бодох урилга юм. Үүнд: сонгох эрх чөлөө ба тэгш боломжийн хоорондох; санаачилгыг дэмжих болон стандарт тогтоох; янз бүрийн арга барил, хэрэгцээт хүн амын бүлгүүдийн хооронд; ТХЗ 4-ийн ойрын болон аажмаар хэрэгжүүлэх амлалтууд (жишээлбэл бүрэн дунд боловсрол); боловсролын болон нийгмийн бусад салбаруудын хооронд зэрэг багтана.

Боловсролын хяналт-шинжилгээний дэлхийн тав дахь тайланг дараах хоёр онлайн хэрэгслээр дэмжинэ. Үүнд: дэлхийн боловсролын тогтолцоон дахь төрийн бус үйл ажиллагаа, зохицуулалтыг тодорхойлсон бодлогын харилцан ярианы эх сурвалж болох PEER; мөн эх сурвалжийг нэгтгэж, цаг хугацааны явцад гүйцэтгэлийн шинэ тооцоог гаргаж өгдөг шинэ вэбсайт VIEW болно.

unesco
Боловсролын хяналт-шинжилгээний дэлхийн тайлан

4 ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛ

Тогтвортой Хөгжлийн Зорилго

www.unesco.org/publishing • wwww.unesco.org/gemreport